

ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2022 – 04 САР | ДУГААР 41

ГАРЧИГ

- 1–4 Бодлогын нийтлэл
- 5–8 Зохицуулалтын мэдээ
- 9–11 Байр суурь
- 12–13 Тогтвортой үнэт цаас
- 14 Иншүртекийн салбарын цаашдын хандлага
- 15–19 Судлаачийн индэр
- 20–21 Санхүүгийн боловсрол /Ногоон даатгал гэж юу вэ?/
- 22 Санхүүгийн тооцоололд суралцъя /хичээл №5/
- 23–24 Компанийн засаглал
- 25–26 Олон улсын зах зээлийн мэдээ
- 27 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

МЭРГЭЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ


Институциональ буюу мэргэжлийн хөрөнгө оруулагчид нь хөрөнгийн зах зээлийн эрэлт талыг бүрдүүлэгч суурь үндэс нь болдог бөгөөд эдгээр мэргэжлийн хөрөнгө оруулагчид нь санхүү, хүний нөөцийн хувьд чадавхжсан, санхүүгийн зах зээлд олон жил ажилласан туршлагатай, өндөр ур чадвартай мэргэжлийн багаар бүрдүүлсэн хуулийн этгээд байдаг. Тухайлбал, мэргэжлийн хөрөнгө оруулагчид нь тодорхой хөрөнгө оруулалтын бодлого, стратегийн хүрээнд урт хугацаанд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэхийн зэрэгцээ өндөр орлоготой, чинээлэг иргэд болон бусад хөрөнгө оруулагчдын сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх замаар тэдгээрийн хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэн хөрөнгийн зах зээлийн хөгжил, эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө үзүүлдэг.

Дотоодын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурь тогтолцоог бүрдүүлэх хүрээнд Улсын Их Хурлаас 2013 онд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийг баталсан. Тус хуулиар хөрөнгө оруулалтын сангийн төрөл, хэлбэр, санг үүсгэн байгуулах, сангийн үйл ажиллагааг эрхлэхтэй холбогдуулан хөрөнгө оруулалтын менежментийн компанид тусгай зөвшөөрөл олгох, сангийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, хөрөнгийг хадгалах, хяналт тавих болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зэрэг харилцааг зохицуулсан. Уг

хууль батлагдсанаар хөрөнгө оруулалтын хуримтлал үүсгэх, дотоодын аж ахуйн нэгжүүд болоод хувь хүмүүс өөрсдийн хөрөнгийг мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчээр дамжуулан удирдуулах эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, тэдгээрийн үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан харилцааг зохицуулсан нэр бүхий 8 журмыг батлан мөрдүүлж байна.

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 32 хөрөнгө оруулалтын менежментийн компани, 24 хувийн хөрөнгө оруулалтын сан, 2 хамтын хөрөнгө оруулалтын сан хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байна. Сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалтын сангийн тоо өсөж байгаа нь нэг талаас жижиг хөрөнгө оруулагчид өөрийн сул чөлөөтэй мөнгөн хөрөнгөө мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх этгээдээр дамжуулан санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж, ашиг, өгөөж хүртэх бололцоо нэмэгдэж байгаа бол нөгөө талаас олон улсын санхүүгийн зах зээлд өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн хөрөнгө оруулагчид болох хамтын сангууд бий болох, гадаадын хөрөнгө оруулалтын дотогш урсгалыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.


Үргэлжлэл 2-р нүүрт



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТ

Ердийн хадгаламжаас илүү өндөр хүү санал болгодог бөгөөд тодорхой хугацаа болон дүн бүхий хадгаламжаар баталгаажсан үнэт цаас/хадгаламжийн бүтээгдэхүүний төрөл



CERTIFICATE OF DEPOSIT

Type of saving account that carries a specified minimum deposit and term and generally provides a higher yield than passbook-type saving accounts

*Эх сурвалж:
Банк санхүүгийн тайлбар толь бичиг*



БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

МЭРГЭЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

Өмнөх нь 1-р нүүрт

Дотоодын хөрөнгийн зах зээлд чанартай, хөрвөх чадвартай бүтээгдэхүүний тоо өсөж байгаа нь мэргэжлийн хөрөнгө оруулагчид олноор бий болж, үйл ажиллагаа нь улам өргөжихөд чухал нөлөө үзүүлэх боломжтой ба Санхүүгийн зохицуулах хорооны хувьд дотоодын мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурийг сайжруулах чиглэлээр тодорхой бодлого, зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж ирсний үр дүнд 2020 онд анхны хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан бий болж байсан түүхтэй /Үндэсний хувьчлалын сан/. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 147, 148 дугаар тогтоолоор “Мандал хуримтлал”, “Хөрөнгө оруулагч үндэстэн” зэрэг хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сан үүсэн байгуулах баримт бичгийг бүртгэн дотоодын хөрөнгийн зах зээлд анхны хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангууд бий болох эхлэл тавигдаж байгааг онцлох нь зүйтэй.

Дотоодын зах зээл дэх мэргэжлийн хөрөнгө оруулагчид: Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.19-т хөрөнгө оруулалтын сан, тэтгэврийн сан, банк, ББСБ, даатгал, андеррайтер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдийг мэргэжлийн хөрөнгө

оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч гэж тодорхойлсон бөгөөд дотоодын зах зээлд хамтын ХОС-аас гадна бусад дээрх компаниуд мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх боломжтой юм.

Банкуудын хувьд банкны салбарын реформын хүрээнд банкны системд нөлөө бүхий банкууд IPO хийх замаар нийт 633 орчим тэрбум төгрөгийг олон нийт, хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлэх урьдчилсан тооцоо гарсан ба эдгээр банкуудын IPO амжилттай хэрэгжсэнээр зах зээлийн үнэлгээ 5.6 их наяд төгрөгөөр нэмэгдэж, улмаар 2022 оны 6 дугаар сарын эцэст нийт зах зээлийн үнэлгээ 10.0 их наяд төгрөгийг давах эерэг хүлээлт байна. Банкны тухай хуулийн 17.4-т “Энэ хуулийн 17.5-д зааснаас бусад тохиолдолд банкны худалдан авах үнэт цаасны нийт дүн нь банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй бөгөөд нэг компанийн гаргасан хувьцааны 10 хувиас дээшгүй байна. Үүнд, Засгийн газар, Төв банкны үнэт цаас, зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн хувьцаа хамаарахгүй” гэж заасан. 2021 оны жилийн эцсийн байдлаар системийн 5 банкны өөрийн хөрөнгийн хэмжээ 3.9 их наяд төгрөг бөгөөд үүний

20 хувь буюу 780.8 тэрбум төгрөгөөр санхүүгийн хэрэгслийг худалдан авч, дотоодын зах зээлд хөрөнгө оруулалт хийх боломж харагдаж байна.


Даатгалын компаниудын хувьд даатгалын нөөц сангийн хөрөнгөөс үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалт хийхэд тавигдах нөхцөл, шаардлага, хязгаарыг тогтоож өгсөн бөгөөд Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэгдсэн компанийн хувьцаанд нөөц сангийн 20 хувь, II ангилалд бүртгэгдсэн компанийн хувьцаанд нөөц сангийн 5 хувийг тус тус хөрөнгө оруулахаар зохицуулсан. 2021 оны жилийн эцсийн байдлаар даатгалын салбарын хэмжээнд нөөц сангийн хэмжээ 78.96 тэрбум төгрөг байгаа бөгөөд нөөц сангийн 20 хувь буюу нийт 15.79 тэрбум төгрөгийг хөрөнгийн зах зээлд оруулах боломжтой байна.

ББСБ-ын худалдан авах үнэт цаасны эзэмшлийн нийт дүн нь өөрийн хөрөнгийн 50 хувиас хэтрэхгүй байна. Мөн Монголын хөрөнгийн биржийн I, II ангилалын компанийн худалдан авсан хувьцааны нийт дүн нь өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй ба нэг компанийн гаргасан хувьцааны нийт дүнгийн 20 хувиас

дээшгүй байна гэж Санхүүгийн зохцуулах хорооны журмаар зохицуулсан. 2021 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-уудын өөрийн хөрөнгийн хэмжээ 1.8 их наяд төгрөг байгаа бөгөөд хамгийн ихдээ буюу 20 хувиар тооцож үзэхэд 359.82 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хөрөнгийн зах зээлд оруулах боломжтой харагдаж байна. **ҮЦК**-уудын хувьд 2021 оны 3 дугаар улирлын байдлаар өөрийн хөрөнгөөр нийт 1.9 тэрбум төгрөгтэй тэнцэхүйц гадаад улсын үнэт цаасыг худалдан авсан нь дотоодын хөрөнгийн зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчаар оролцох бололцоотой.

Олон улсын туршлага, нийтлэг чиг хандлага: Олон улсын туршлагаас харахад хөгжиж буй улсуудын компанийн бондын зах зээлийн 27 хувийг банк, санхүүгийн байгууллагууд, 18 хувийг хөрөнгө оруулалтын сан, 15 хувийг тэтгэврийн сан, 9 хувийг даатгалын компани, 7 хувийг корпораци, 9 хувийг жижиг хөрөнгө оруулагчид үдсэн нь 15 хувийг бусад бүрдүүлж байгаа нь мэргэжлийн хөрөнгө оруулагчдын үүрэг оролцоо санхүүгийн зах зээлд чухал нөлөөтэй болохыг харуулж байна.

Зураг. Бондын зах зээлийн хөрөнгө оруулагчийн бүтэц



Болгар улсад хамтын хөрөнгө оруулалтын сангийн компанийн бондод хөрөнгө оруулах хэмжээ 10 хувиас, тэтгэврийн сан 25 хувиас, даатгалын компани 80 хувиас хэтрэхгүй байх ёстой. Харин Бразил Улсын хувьд хамтын хөрөнгө оруулалтын сан бүх хөрөнгөө компанийн бондод оруулж болохоор заасан байдаг. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн хувьд бол Америкийн нэгдсэн улсад өндөр хөгжсөн байдаг бөгөөд нийт үйл ажиллагаа явуулж буй хамтын хөрөнгө оруулалтын сангийн 46 хувийг дангаар бүрдүүлдэг. Харин 34 хувийг Европын орнууд, 15 хувийг Ази болон Африкийн орнууд, үлдсэн 5 хувийг бусад орнууд эзэлдэг.

Австралийн ирээдүйн сан 2006 онд байгуулагдсан бөгөөд урт хугацаанд улсын эдийн засаг, санхүүгийн байдлыг сайжруулах зорилготой сан юм. Сангийн орлогын эх үүсвэр нь нүүрс, зэсийн орлого бөгөөд жил бүрийн тэнцвэржүүлсэн төсвийн ашиг уг сангийн орлого болдог. Харин зарцуулалтын хувьд ирээдүйд төсөвт учрах иргэдийн тэтгэврийн зардлын өсөлтөөс бий болох төлбөрийг санхүүжүүлэх зорилготой. Сангийн орлогын эх үүсвэр нь жил бүрийн тэнцвэржүүлсэн төсвийн ашиг болон Австралийн Засгийн газрын Телстра компанид эзэмших хувьцааг шилжүүлэн авснаас орох орлого болон уг хувьцааг борлуулснаас орох орлогоос бүрддэг. Ирээдүйн сангийн тухай хуульд сангийн анхны хөрөнгийг 18 тэрбум доллар байхаар тогтоон шилжүүлсэн. Ирээдүйн сангийн тухай хуульд тус сангаас 2020 он хүртэл үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх болон зорилтот хөрөнгийн хэмжээг бүрдүүлснээс бусад нөхцөлд зарцуулалт хийхгүй байхаар заасан байдаг. Тус сангийн санхүүгийн хөрөнгө оруулалтын бодит өгөөжийг 4.5–5.5 хувьд байлгах зорилготой бөгөөд сангийн нийт хөрөнгийн 70%–ийг гадаад зах зээл дээр, 30%–ийг дотоод зах зээлд байршуулдаг.

Норвегийн Вант Улсын хувьд 1990 онд Газрын тосны сангийн тухай хуулийг батлан, улмаар Засгийн газрын Глобал тэтгэврийн сан үүсгэн байгуулсан. Тус сан нь улсын газрын тосны бүх орлого, газрын тосны үйл ажиллагаатай холбоотой бүхий л санхүүгийн үйл ажиллагаанаас орох орлого болон сангийн үр өгөөжөөс бүрддэг. Сангийн хөрөнгийг улсын төсөвтэй бүрэн нэгтгэсэн бөгөөд төсвийн ашгийг /газрын тосны орлогыг оролцуулан/ тус санд төсвөөр дамжуулан төвлөрүүлдэг. Сангийн хөрөнгийг зөвхөн гадаадад хөрөнгө оруулалт хийдэг. Ингэснээр дотоодын эдийн засгийг мөн валютын ханшийг газрын тосны орлогын хэлбэлзлээс хамгаалахыг зорьсон. Сангийн хөрөнгийг бодит үр өгөөж нь 4 хувь ба түүнээс дээш байх хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнд тус сан нь хөрөнгө оруулалт хийдэг. Сангийн хөрөнгийн 40 хүртэлх хувийг олон улсын хөрөнгийн зах зээл дээрх хувьцаа, засгийн газрын үнэт цаас зэрэг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийж байсан бол 2009 оны 6 дугаар сард гарсан Норвегийн Вант Улсын Сангийн яамны шийдвэрээр уг хэмжээг 60 хүртэл хувь

болгон нэмэгдүүлсэн. Тус сан нь Засгийн газрын бус үнэт цаасанд 2002 оноос эхлэн хөрөнгө оруулалт хийж эхэлсэн бол 2010 оноос сангийн хөрөнгийг 5 хүртэлх хувийг үл хөдлөх хөрөнгөнд хөрөнгө оруулалт хийх талаар шийдвэр гарсан.

Бодлого, зохицуулалтын арга хэмжээ: дотоодын хөрөнгийн зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурийг нэмэгдүүлж, урт хугацааны хөрөнгө оруулалтын тогтолцоог боловсронгуй болгох замаар гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын урсгалыг өсгөн хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих хүрээнд хөрөнгө оруулалтын сан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанийн эрх зүйн зохицуулалтын орчныг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага үүсэж байсан ба энэ хүрээнд Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 05–ны өдрийн 52 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Хөрөнгийн зах зээлийн холбогдох хууль эрх зүйн орчин шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий” ажлын хэсгээс Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцэслэн боловсруулж, 2022 оны Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.

Дээрх хуулийн төслөөр хөрөнгө оруулалтын сангийн хуулийн этгээдийн хэлбэрийг өргөтгөж гэрээний буюу хуулийн этгээдийн эрхгүй хэлбэрээр хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулах актив буюу санхүүгийн хэрэгслийн нэр төрлийг нэмэгдүүлэх, хамтын сангийн шинэ төрөл болох биржээр арилжаалагддаг сан /Exchange traded fund/–г бий болгох, хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын санд тавигддаг нөхцөл шаардлагыг тус тусад нь нарийвчлан зохицуулж, хялбаршуулах зэрэгтэй холбоотой зохицуулалтын өөрчлөлтүүдийг хуулийн төсөлд тусгасан. Уг хуулийн өөрчлөлтүүд батлагдсанаар хамтын хөрөнгө оруулалтын сангийн шинэ төрөл бий болж, сангийн үйл ажиллагаа өргөжин хөрөнгийн зах зээл, эдийн засагт гүйцэтгэх үүрэг оролцоо нь сайжрахаас гадна дотоодын мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурь тогтолцоо сонгодог утгаар бүрдэх боломж бий болно.



ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

ИРГЭД, ОЛОН НИЙТЭД АНХААРУУЛАХ НЬ

Өнгөрсөн хоёрдугаар сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулиар “виртуал хөрөнгө”-ийг аливаа улсын албан ёсны мөнгөн тэмдэгт, үнэт цаасны дижитал хэлбэр, эсхүл Монголбанкны зөвшөөрөлтэй цахим мөнгөнөөс бусад дижиталаар шилжүүлэх, арилжаалах боломжтой төлбөрийн, эсхүл хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглагдах үнэ цэнийн дижитал илэрхийлэл бүхий эдийн бус хөрөнгийг хэлнэ хэмээн тодорхойлсон. Улс орнууд виртуал хөрөнгийг өөрийн орны эрх зүйн орчинд нийцүүлэн харилцан адилгүй тодорхойлсон ч үүний эрсдэл өндөр, үнийн хэлбэлзэл ихтэй, аливаа биет хөрөнгөөр баталгааждаггүй бөгөөд дэлхий дахинаа шинээр зохицуулалтад орж буй салбар тул хэрэглэгч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах эрх зүйн зохицуулалт дутмаг байдлыг нийтлэг хүлээн зөвшөөрөөд байна. Тухайлбал, өнгөрсөн гуравдугаар сарын 17-ны өдөр Европын банкны хяналтын газар, Европын үнэт цаас, зах зээлийн хяналтын газар болон Европын даатгал, хөдөлмөрийн тэтгэврийн газраас криптовалютын эрсдэлийн талаар хамтарсан мэдэгдэл, анхааруулгыг гаргасан байна. Энэхүү анхааруулгад виртуал хөрөнгөнд хөрөнгө оруулах гэж буй этгээдүүд нь оруулсан бүх хөрөнгө мөнгөө алдах эрсдэлтэй гэдгээ бүрэн ухамсарлах, олон нийтийн цахим сүлжээгээр явж буй худал, төөрөгдүүлсэн мэдээлэлд автахгүй байх, хурдан хугацаанд өндөр өгөөж амласан хөрөнгө оруулалтуудаас болгоомжлохыг онцолжээ. Мөн Европын холбооны өнөөгийн зохицуулалтын орчны хүрээнд крипто хөрөнгө болон холбогдох бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой асуудлаар хэрэглэгч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах боломж хомс байгааг анхааруулсан байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос мэдэгдэл, анхааруулга, сэрэмжлүүлгийг иргэд, олон нийтэд зориулан тасралтгүй хүргэсээр байна. Хэдийгээр Виртуал хөрөнгийн үйлчилгээ



үзүүлэгчийн тухай хууль батлагдаж салбарын эрх зүйн орчин бүрэлдсэн ч виртуал хөрөнгийн үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааны үр дүнд үүссэн хохирлыг төр хариуцах боломжгүй билээ. Иймд, иргэд Та бүхэн аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийхдээ тухайн хөрөнгийн бодит шинж чанар, үүсэж болзошгүй эрсдэлийн талаар бүрэн дүүрэн мэдээлэлтэй байхын зэрэгцээ холбогдох судалгаа, шинжилгээг хийж, хохирлоос урьдчилан сэргийлж ажиллахыг зөвлөж байна.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГ ХЭЛЭЛЦЛЭЭ



Санхүүгийн зохицуулах хороо УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо /ЭЗБХ/-нд жил бүр үйл ажиллагаагаа тайлагнах үүрэг хүлээдэг. Энэ дагуу Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, орон тооны гишүүд, Ажлын албаны дарга болон холбогдох газрын дарга нарын төлөөлөл 2021 оны ажлын тайлангаа ЭЗБХ-ны хуралдаанаар хэлэлцүүлж дүгнүүллээ. Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой 27 хууль, 111 дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Тайлантай холбоотойгоор Байнгын хорооны дарга Ж.Ганбаатар, гишүүн Б.Энхбаяр, Ч.Хүрэлбаатар, М.Оюунчимэг, Х.Булгантуяа, Т.Доржханд нар Санхүүгийн зохицуулах хороо хэдийгээр цар тахлын хүнд нөхцөлд байсан ч бодлого, зохицуулалтын оновчтой арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлж ажилласан гэж дүгнэв. Түүнчлэн шаардлагатай хуулиудыг хугацаа алдалгүй УИХ-аар батлуулах, банк, төрийн өмчит болон томоохон компаниудыг олон нийтийн болгох чиглэлд анхаарч ажиллах, технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжих, ФАТФ-аас хийх 2023 оны харилцан үнэлгээ, УИХ-аас батлан гаргасан хуулиудын хэрэгжилтийг хангах хүрээнд анхаарч ажиллах, зах зээлд гарсан ахиц дэвшлээ бататгахыг зөвлөлөө.

ХҮРТЭЭМЖТЭЙ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ТАЛААР ЧУУЛЛАА



“IPO MONGOLIA 2022–Хүртээмжтэй хөрөнгийн зах зээл” чуулга уулзалт өнөөдөр боллоо. Чуулга уулзалтаар хөрөнгийн зах зээл дээрх бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх, төрийн өмчит компаниудыг биржээр дамжуулан нээлттэй хувьцаат компани болгох ач холбогдол, IPO хийхэд компанийн үнэлгээний үр өгөөж, олон улсын стандартууд, гадаадын хөрөнгө оруулалт татах боломж, банкны салбарын реформ, бондын зах зээл болон тогтвортой хөрөнгийн зах зээл зэрэг өргөн сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлж хөрөнгийн зах зээлийн хөгжлийн хурдыг нэмэгдүүлэх гарц, шийдлийг хайлаа. Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан чуулга уулзалтыг нээж хэлсэн үгэндээ “Санхүүгийн зохицуулах хороо хөрөнгийн зах зээлийн өсөлтийг дэмжих, эдийн засаг, байгаль орчин, нийгэмд гүйцэтгэх үүргийг идэвхжүүлэх бодлогын нэлээдгүй ажлуудыг гүйцэтгэсэн. Тухайлбал, дэд бүтцийн орчинг олон улсын жишигт нийцүүлэх чиглэлээр үнэт цаасны арилжааны дараа төлбөр тооцоог Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас гаргасан бодлогын зөвлөмж, суурь зарчмын хүрээнд T+2 горимд шилжүүлж, төлбөрийн эсрэг нийлүүлэлт /DvP/ зарчмыг нэвтрүүлснээр үнэт цаасны зах зээлийн төлбөр тооцоо олон улсын жишигт нийцэж, гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоо өсөх суурь нөхцөл бүрдлээ. Мөн үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн тогтолцоог шинэчлэх, төвлөрсөн болон тухайлсан бүртгэл хоорондын уялдаа холбоог хангах, брокерийн компаниудын чадавхыг сайжруулж, харилцагчдад үзүүлэх үйлчилгээг түргэн шуурхай болгох чиглэлээр мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны номинал дансны зохицуулалтыг олон улсын жишгийн дагуу боловсруулж, баталсан. Түүнчлэн “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг баталж компаниудын хувьд хаалттай өрийн хэрэгслийг арилжаалах, биржийн бус зах зээлээс санхүүжилт босгох, хаалттай өрийн хэрэгслийн хоёрдогч зах зээл үүсэх боломжийг бүрдүүлсэн юм. Олон улсын хөрөнгийн

зах зээлийн интеграцад нэгдэх, гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудыг дотоодын биржид давхар бүртгэх чиглэлээр Үнэт цаасны давхар бүртгэлийн журамд хөрөнгө оруулагчид дотоодын болон гадаадын биржүүдийн хооронд үнэт цаасаа чөлөөтэй хөрвүүлэн арилжаалах зохицуулалтыг бий болгож, өмчлөх эрхийн бүртгэлийн холимог тогтолцоог бий болголоо. Мөн Азийн хөгжиж буй болон хөгжингүй хөрөнгийн зах зээлтэй орнуудад түгээмэл хэрэглэгддэг хадгаламжийн бичгийг хөгжүүлэх чиглэлээр хадгаламжийн бичгийг бүртгэх, нийтэд санал болгон арилжих журмыг баталсан. Ингэснээр дотоодын аж ахуйн нэгжүүд гадаад улсад хадгаламжийн бичиг гаргах, гадаадын аж ахуйн нэгжүүд Монгол Улсын хадгаламжийн бичгийг гаргах боломж бүрдээд байна.



Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр хувьцаат компаниудын ногдол ашгийг жижиг хувьцаа эзэмшигч нарт чирэгдэлгүй хурдан шуурхай тараах ажиллагааг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаар дамжуулан хувьцаа эзэмшигч бүрийн арилжааны банкны дансанд байршуулах зохицуулалтыг мөн бий болгосон. Харин одоо олон улсын жишигт нийцсэн хөрөнгийн зах зээлийг бий болгож, олон улсын хөрөнгө оруулагчид хөрөнгөө таатайгаар байршуулах, түүгээр зогсохгүй бүс нутгийн болон олон улсын санхүүгийн төв болох боломж бидэнд бий. Иймд өнөөдрийн чуулга уулзалтаар дараагийн 5–10 жилд хөрөнгийн зах зээлийн хөгжлийг тодорхойлох чухал бодлогын саналууд гарна гэдэгт итгэлтэй байна” гэдгийг онцоллоо.

Мөн чуулга уулзалтын “Банк олон нийтэд нээлттэй компани болохын давуу тал, хөрөнгийн зах зээлд үзүүлэх нөлөө” хэлэлцүүлэгт Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал, “Хөрөнгийн зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурийг нэмэгдүүлэх” хэлэлцүүлэгт Ажлын албаны дарга Т.Жамбаажамц оролцохын зэрэгцээ Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн “Монголын хөрөнгийн зах зээлийн ирээдүйн төлөв, хөгжлийн бодлого, зохицуулалт” сэдвээр илтгэл тавьсан юм.

СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО



Санхүүгийн зохицуулах хорооноос 17 даатгалын компани, итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 54 банк бус санхүүгийн байгууллагуудын гүйцэтгэх захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нарт зориулсан сургалт, хэлэлцүүлгийг энэ сарын 12, 13-ны өдрүүдэд зохион байгууллаа. Энэ үеэр шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс” болон “Даатгагчийн нээлттэй ил тод байдал, засаглалын чиглэлийн асуудлууд”, “Даатгалын хяналт шалгалт, нөхөн төлбөрийн өргөдөл, гомдол”-ын талаар сургалт мэдээлэл өглөө. Мөн итгэлцлийн үйлчилгээ эрхэлж буй банк бус санхүүгийн байгууллагуудын бодлого, зохицуулалт, зайнаас тавих хяналтын хүрээнд анхаарах гол асуудлуудын талаар танилцуулсан юм.

Цаашилбал засаглалын кодекс, банк бус санхүүгийн байгууллага, даатгалын салбарт тулгамдсан бусад асуудлын талаар хэлэлцүүлэг өрнүүлж, санал солилцлоо. Үүний үр дүнд холбогдох компаниудын эрх бүхий албан тушаалтнууд Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, шинэчлэн батлагдсан засаглалын кодекс, санхүүгийн тайлагналын хугацаа, тоон мэдээлэл, нөхөн төлбөртэй холбоотой өргөдөл гомдол, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар мэдээлэлтэй боллоо.

ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ХОЛБОГДОХ ЖУРМУУДЫГ БАТАЛЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны ээлжит долдугаар хуралдаанаар Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн холбогдох журмуудыг баталлаа.

Монгол Улсад виртуал хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангаж хөгжлийг дэмжих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, гадаад хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэхээс гадна Санхүүгийн хориг

арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/-ын Зөвлөмж 15-ын хэрэгжилтийг хангах үүднээс Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг боловсруулсан. Улмаар УИХ-аас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталж, энэ оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

Иймд Санхүүгийн зохицуулах хорооноос “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам”, “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”, “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавих нөхцөл, шаардлагыг тогтоох журам”, “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тогтоох журам”-ын төслүүдийг боловсруулж, олон нийтээс санал авахаар Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудсанд байршуулсан. Мөн журмын төслүүдийг төрийн байгууллага, виртуал хөрөнгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй этгээд, олон нийтийн төлөөллийг хамруулан 6 удаа хэлэлцүүлэг өрнүүлсний зэрэгцээ санал авах ажлыг Азийн сан, “Монголын биржүүдийн нэгдсэн холбоо” ГҮТББ-тай хамтран зохион байгуулсан. Энэ хугацаанд төрийн байгууллага, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, иргэдээс нийт 324 саналыг ирүүлснийг хүлээн авч хэлэлцүүлсэн юм.

Санхүүгийн зохицуулах хорооны ээлжит хуралдаанаар журмуудыг баталснаар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох, нарийвчилсан харилцааг тодорхой болгох, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, ФАТФ-ын зөвлөмжийн биелэлтийг хангах нөхцөл бүрдлээ. Тодруулбал, “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам”-аар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгэх, бүртгэхээс татгалзахтай холбоотой харилцааг, “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”-аар зохистой засаглал, үйл ажиллагаа, өөрийн хөрөнгийн хэмжээ, тайлан мэдээнд тавигдах шаардлагыг тодорхойлохтой холбогдох харилцаа, ФАТФ-ын “аяллын дүрэм”-ийн харилцааг зохицуулсан. Харин “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавих нөхцөл, шаардлагыг тогтоох журам”-аар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэхэд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоохтой холбоотой харилцааг, “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тогтоох журам”-аар Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тогтоосон юм.

“ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧДИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ НЬ” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО



Санхүүгийн зохицуулах хороо Азийн сантай хамтран “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн зохицуулалтын орчныг бүрдүүлэх нь” хэлэлцүүлгийг энэ сарын 04-ний өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлгийг нээж Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан хэлсэн үгэндээ “Сүүлийн жилүүдэд дэлхий нийтэд виртуал хөрөнгийг тойрсон төрийн зохицуулалтын шинэ сорилтууд бий болж байна. Иймд Санхүүгийн зохицуулах хорооноос олон улсын стандарт, ФАТФ-ын зөвлөмжид нийцсэн, эрсдэлийг бууруулж, инноваци, шинэчилэлийг дэмжсэн, санхүүгийн зах зээлийн өсөлтийг хангасан зохицуулалтын зохистой орчныг бүрдүүлэхээр ажиллаж байна” гэдгийг онцолсон юм.



Хэлэлцүүлгийн эхэнд журмын төслүүдийн товч танилцуулга, ирүүлсэн санал болон тэдгээрийг хэрхэн тусгаж оруулсан талаар мэдээллийг өглөө. Түүний дараа виртуал хөрөнгийн салбарын зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр журмын төслүүд, зөрүүтэй саналуудыг хэлэлцэж, нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэв. Энэ удаагийн хэлэлцүүлэгт виртуал хөрөнгийн үйлчилгээ

үзүүлэгчид, Монголын биржүүдийн нэгдсэн холбоо, Монголын блокчэйн технологи ба криптовалютын холбоо зэрэг нэр бүхий мэргэжлийн холбоод, холбогдох төрийн байгууллагуудын төлөөллөөс гадна койн/токен гаргах замаар иргэд, олон нийтээс санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлсэн этгээдүүд оролцсон юм.



Санхүүгийн зохицуулах хороо Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн дагуу нийт 10 орчим харилцааг зохицуулах 8 журмыг боловсруулахаар ажиллаж байна. Одоогийн байдлаар “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бүртгэлийн журам”, “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам” зэрэг нэр бүхий 4 журмын төслийг боловсруулж олон нийтээс санал авахаар Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудсанд байршуулсан. Мөн дээрх журмын төслүүдэд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид, тэдгээрийн мэргэжлийн холбоод, койн/токен гаргагчид, иргэд, олон нийтээс гадна төрийн байгууллагуудаас ирүүлсэн саналыг тусгасны зэрэгцээ олон нийтийг хамарсан хэлэлцүүлгийг удаа дараа зохион байгуулсан. Харин эцсийн хэлэлцүүлгийг Азийн сантай хамтран танхим, цахим хосолсон хэлбэрээр ийнхүү зохион байгууллаа.



БАЙР СУУРЬ

ДААТГАЛЫН САЛБАРЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Энэ удаагийн ярилцлагаар даатгалын салбар дахь эрсдэлийн удирдлагын талаар Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Батболдтой ярилцлаа.



Даатгал бол бусад бизнесээс ялгаатай буюу ирээдүйд учирч болох санхүүгийн хүндрэлээс даатгуулагч нарыг хамгаалдаг эрсдэлийн удирдлагын хэрэгсэл гэж ойлгодог. Даатгалаар ер нь ямар эрсдэлийг даатгадаг вэ? Даатгагдаж болохгүй эрсдэл гэж байх уу?

Байгалийн гамшигт үзэгдэл, гал түймэр, газар хөдлөлт, гэнэтийн осол аюул зэрэг тохиолдох хугацааг урьдчилан тооцох боломжгүй, гэнэтийн шинжтэй эрсдэлүүд хувь хүн, аж ахуйн нэгж байгууллага болон төрд байнга тохиолдож байдаг. Сүүлийн жилүүдэд эрсдэлийн төрөл, эрсдэл тохиолдох магадлал улам бүр нэмэгдэж байгааг бид бүгд мэдэж байгаа. Тухайлбал, техникийн, ахуйн, байгалийн, зам тээврийн осолд өртөх, өвчин эмгэг тусгах гээд л төрөл бүрийн эрсдэлүүд бидний амьдралд учирсаар л байна. Сүүлийн 16 жилд бүртгэгдсэн гамшиг, аюулт үзэгдэл, ослын нийт тоо 56,964, эдгээрийн улмаас амь эрсэдсэн нийт хүний тоо 3183, бэртэж түлэгдсэн хүний тоо 8502 гээд нийт 1.2 их наяд төгрөгийн хохирол учирсан статистик үзүүлэлт байна. Дунджаар жилд 3800 орчим, сард 320 орчим, хоногт 10 орчим гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолддог байна.

Хэдийгээр бид эрсдэл тохиолдох, учрах магадлалыг бууруулж чадахгүй ч гэлээ эдгээр эрсдэлийг шилжүүлэх, гарз хохирол багатайгаар даван туулах арга байгаа бөгөөд хамгийн оновчтой хэлбэр нь даатгал юм гэдгийг олон улсад аль хэдийн хүлээн зөвшөөрсөн.

Ерөнхийдөө хүний амь нас, эрүүл мэнд, бусдын өмнө хүлээх хариуцлага, аливаа эдийн болон эдийн бус хөрөнгө, түүнчлэн хуульд харшлаагүй ашиг сонирхол гээд бүхий л зүйлийг аливаа эрсдэлээс даатгах боломжтой бөгөөд даатгагдсан үед эрсдэл тохиолдсоны улмаас үүдсэн хохирлыг даатгалын компаниар нөхөн төлүүлдэг.

Хууль тогтоомжийн хүрээнд даатгалыг урт хугацааны болон ердийн даатгал гэж ангилдаг. Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 207 дугаар тогтоолоор эдгээр ангилал тус бүрд хамаарах даатгалын хэлбэрийг баталсан байдаг бөгөөд тэрхүү тогтоолоор даатгалын компаниуд ямар бүтээгдэхүүнээр ямар эрсдэлийг даатгах боломжтой байдаг талаарх ойлголтыг авах боломжтой.

Гэхдээ эрсдэлийг шинж чанараар нь авч үзвэл хүлээгдээгүй, тодорхойгүй байх шаардлагатай. Үүнээс үүдэлтэйгээр даатгагдаж болохгүй эрсдэл гэж мөн байдаг ба эдгээрт мөрийтэй тоглоом, цэрэг дайны үйл ажиллагаа, хөрөнгийн зах зээл дэх арилжаа болон хууль бус үйл ажиллагаа зэрэг орно.

Даатгал бол ирээдүйд учрах хохирлын үед нөхөн төлбөр авах зорилгоор өнөөдөр мөнгө төлж байгаа амлалт худалддаг бизнес гэж харагдаж байна. Тэгэхээр ирээдүйд даатгуулагчид өгөх мөнгөө даатгалын компаниуд хэрхэн нөөцөлж хадгалдаг вэ?

Даатгалын ангиллаас шалтгаалаад даатгалын компани тус бүр гэрээний явцад үүссэн үүргийн гүйцэтгэлийг хангах, ирээдүйд учирч болзошгүй хохиролд зориулан даатгалын нөөц санг тусгайлсан аргачлалын дагуу байгуулдаг. 2021 оны жилийн эцсийн байдлаар даатгалын компаниуд 79.0 тэрбум төгрөгийн даатгалын нөөц сан, 113.0 тэрбум төгрөгийн орлогод тооцоогүй

хураамжийн нөөцийг хуримтлуулсан. Сонирхуулан хэлэхэд, даатгалын салбарын хувьд даатгагчид учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан үнэлж, эдийн засаг, математикийн тооцоо, судалгааны үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг актуарч нар энэхүү даатгалын нөөц санг тооцоолдог. Ер нь даатгал бол санхүүгийн салбар дотроо ч нэлээдгүй нарийн үйл ажиллагаагаар хэрэгждэг мэргэжлийн салбар тул даатгагч нар даатгалын нөөц санг хангалттай, хүрэлцээтэй, үнэн зөв байгуулах, мөн тухайн нөөц сангаас хөрөнгө оруулалт хийх асуудал чухал байдаг.

Даатгалын компаниуд ямар хэлбэрээр өөрийн хөрөнгөө хөрөнгө оруулалтад байршуулдаг вэ?

Даатгалын тухай хууль болон холбогдох дүрэм, журмаар даатгалын компанийн нөөц сангаас хийх хөрөнгө оруулалтын ангилал, хөрөнгө оруулж болох дээд хувийг зааж өгсөн байдаг. Даатгалын компаниуд даатгалын нөөц сангийн хөрөнгөө мэдээж банк, банк бус санхүүгийн байгууллагад байршуулж болохоос гадна үнэт цаас, өрийн хэрэгсэл, хувьцаа хэлбэрээр хөрөнгийн зах зээлд заасан хувь, хэмжээний хүрээнд байршуулах бүрэн боломжтой.

Олон улсад даатгалын компаниуд хөрөнгийн зах зээл дээр гол тоглогчид буюу мэргэжлийн институциональ хөрөнгө оруулагч хэлбэрээр оролцдог. Даатгалын болон хөрөнгийн зах зээл нь нягт уялдаа холбоотойгоор хамтран ажиллаж, зэрэгцэн хөгжсөнөөр улс орны санхүүгийн зах зээлд томоохон эерэг өөрчлөлт, нөлөөллийг авч ирдэг гэж хэлж болно. Даатгалын салбарын хувьд 4 компани олон нийтэд хувьцаагаа нээлттэй арилжаалж байна.

Энэ ч утгаараа Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс даатгалын компанийн хөрөнгийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.9-т заасан компанийн өрийн хэрэгсэлд даатгалын компаниудын хөрөнгө байршуулах дээд хэмжээг 30 хувь, Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй компанийн хувьцаанд хөрөнгөө байршуулах дээд хэмжээг 20 хувь байсан өмнөх зохицуулалтаас тус тус 10 хувиар нэмэгдүүлсэн бөгөөд 2021 оны жилийн эцсийн байдлаар даатгалын компаниудын бонд, хувьцаа хэлбэрээр хөрөнгийн зах зээлд оруулсан нийт хөрөнгө оруулалт 65.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 140.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс, компанийн өрийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалт 2020 оны байдлаар 17.5 тэрбум төгрөг байсан бол 2021 оны байдлаар 141.2 хувиар өсөж 42.2 тэрбум төгрөг, Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй компанийн

хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт өмнөх оноос 96.4 хувиар өсөж, 10.8 тэрбум төгрөгт тус тус хүрээд байна.

Даатгалын компанийн нөөц сангийн зохицуулалтын хувьд ийм байна. Харин даатгалын компанийн дүрмийн сан болон бусад эх үүсвэрийн хувьд өөрсдөө эрсдэлээ тооцсоны дагуу аливаа хэлбэрээр байршуулж болох ч Санхүүгийн зохицуулах хорооноос тавьж буй төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтээр үүнд тодорхой хязгаарлалтыг тавьдаг.

Даатгалын нөөц сангаас гадна даатгалын компанийн бусад санхүүгийн чадавх болон төлбөр гүйцэтгэх чадварт нь холбогдох хяналтыг хэрэгжүүлдэг байх?

Мэдээж тэгэлгүй яахав. Зөвхөн даатгалын нөөц сангийн бүрдүүлэлт, зарцуулалтаас гадна сая дурдсан даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт гэх үзүүлэлт бий. Энэхүү үзүүлэлт нь даатгагчийн үйл ажиллагаанд учирч болох бүхий л эрсдэлийг тооцоолсны үндсэн дээр даатгагчийн эрсдэлгүй буюу зөвшөөрөгдөх хөрөнгө нь даатгагчийн үүргийн гүйцэтгэлийг хангахад хүрэлцэх эсэхийг харуулдаг бөгөөд Олон Улсад Solvency II болон Эрсдэлд суурилсан хөрөнгийн аргачлалаар үзүүлэлтийг тооцоолдог. Манай улсын хувьд 2018 онд Эрсдэлд суурилсан хөрөнгийн тооцооллын хялбарчилсан загварыг гарган даатгалын компаниудад туршилтаар хэрэгжүүлсэн бол одоогоор бүрэн хэрэгжүүлэхээр судалгаа хийн хууль тогтоомжийн дагуу холбогдох ажиллагаануудыг хэрэгжүүлээд явж байна. Олон улсын түвшинд хэрэгжүүлж буй төлбөрийн чадварын тооцооллын аргачлалын гол тулгуур нь даатгагчийн өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын тооцоолол байдаг. Даатгалын компани бүрийн эрхэлж буй үйл ажиллагааны цар хүрээ, санхүүгийн болон хөрөнгийн чадвар гээд бусад нөхцөл байдал нь бүгд ялгаатай байдаг учраас учирч болох эрсдэл болон төлбөрийн чадвараа ялгаатай тодорхойлох шаардлага сүүлийн үед зайлшгүй тавигдаж байна. Тус аргачлал нь боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой бөгөөд үүнтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооноос мөн холбогдох аргачлалыг гаргахаар ажиллаж байна.

Тэгэхээр даатгагч нар өөрсдөө эрсдэлээ тодорхойлох боломжтой гэж ойлголоо. Үүнтэй холбоотойгоор нэг зүйл нэмээд асуухад, даатгагч нар өндөр үнэлгээтэй, өндөр эрсдэлтэй зүйлийг даатгах тохиолдол гарч ирж болно. Энэ үед даатгагчийн хөрөнгө, санхүүгийн чадавх эсвэл эрсдэл хүлээн авах чадвараас давсан гэж үзэх тохиолдолд даатгалын компаниуд ямар арга хэмжээг хуулийн хүрээнд авах боломжтой вэ?

Даатгалын тухай хуулийн дагуу даатгагч нар өөрийн хүлээж авах эрсдэлээс давсан хэсгийг давхар даатгалын компанид хэсэгчлэн эсхүл бүрэн шилжүүлж болно. 2017–2021 онд буюу сүүлийн 5 жилийн хугацаанд даатгалын компаниуд нийт хураамжийн орлогын 32.1 хувь буюу нийт 310.3 тэрбум төгрөгийг гадагшаа давхар даатгалын хураамжид шилжүүлсэн байна. 2021 оны байдлаар даатгалын компаниуд нийт 243.3 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажилласнаас 84.4 тэрбум /34.7%/ төгрөгийг давхар даатгалын хураамжид зарцуулсан бөгөөд үүний 4.9 хувь буюу 4.2 тэрбум төгрөгийг дотоодын давхар даатгагч болох “Үндэсний давхар даатгал” ХК гэх төрийн өмчит компанид төлжээ. Эдгээр үзүүлэлт нь мэдээж хангалтгүй юм.

Энэ нь нэг талаас дотоодын давхар даатгалын зах зээлийн хөгжил хангалтгүй, нөгөө талаас даатгалын компаниудын эрсдэл хүлээн авах механизм боловсронгуй бус байгаагаас гадагшаа их хэмжээний мөнгөн урсгал бий болж байгааг харуулж байна. Иймээс дотоодын давхар даатгалын зах зээлийг хөгжүүлэх нь гадагшаа гарч буй мөнгөн урсгалыг зохицуулах, мөн даатгалын салбарын хөгжлийг дэмжих гол хөшүүрэг болно гэж харж байна.

Таны хэлсэн тооноос харахад даатгалын хураамжийн 30 орчим хувь нь давхар даатгал хэлбэрээр гадагшаа гардаг байх нь. Гэтэл Монгол улсад ердөө ганц давхар даатгалын компани үйл ажиллагаа явуулж байна. Даатгалын компаниуд давхар даатгалаас өөр хэлбэрээр эрсдэлээ шилжүүлэх боломж байдаг уу?

Газар хөдлөлт, хар салхи гэх мэт байгалийн гамшгийн томоохон эрсдэлийг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр даатгалын салбарт дутагдалтай байдаг тул 1990–ээд оноос эхлэн олон улсад – Alternative Risk Transfer буюу Эрсдэл шилжүүлэх уламжлалт бус арга механизмыг ашиглан давхар даатгагчаас өөр субъектэд даатгалын эрсдэлийг шилжүүлэх, эрсдэлийг санхүүжүүлэх шинэ хөрөнгийн эх үүсвэрийг бий болгож эхэлсэн байдаг. Энэхүү жишгийн дагуу даатгалын эрсдэлд суурилсан үнэт цаас (Insurance linked securities) буюу бонд, үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргах замаар хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгон, даатгалын эрсдэлийг тархаан байршуулж, даатгалын компаниудын эрсдэл даах чадамжийг нэмэгдүүлэх боломжтой байна. Өөрөөр хэлбэл ART нь даатгагч болон давхар даатгагчдад илүү өргөн эх үүсвэрээс

хөрөнгийн дутагдлыг арилгах нөхцөл боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ хөрөнгө оруулагчдад өөрийн багцыг сайжруулан эрсдэлийг тархаан байршуулахад чухал ач холбогдолтой байдаг байна.

Үүнээс гадна нэг даатгагч дангаараа даатгах боломжгүй томоохон эрсдэлийн хувьд хэд хэдэн даатгагч хамтран эрсдэлийг хувааж, хүлээн авах замаар “хамтын даатгал” хийх боломж байдаг. Энэ тохиолдолд тухайн хамтын даатгалын үйл ажиллагааг толгой даатгагч эсхүл давхар даатгалын зуучлагч компани зохион байгуулж оролцдог. Манай улсын хувьд практик дээр даатгалын компаниуд тухайлсан томоохон эрсдэлийг даах зорилгоор хамтарч гэрээ байгуулан гэрээний үндсэн дээр холбогдох харилцааг хэрэгжүүлж байгаа тохиолдлууд цөөн хэд байгаа. Гэхдээ энэхүү хэлбэрийг даатгалын салбарт нэвтрүүлэх, боловсронгуй болгох асуудал анхаарлын төвд хэвээр байна.

Давхар даатгал болон даатгалын эрсдэл шилжүүлэх бусад арга хэрэгслүүдийг боловсронгуй болгох чиглэлээр зохицуулагч байгууллагын хувьд Санхүүгийн зохицуулах хорооноос ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа вэ?

УИХ, Засгийн газраас боловсруулсан бодлогын баримт бичгүүдэд Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай болон Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлууд тусгагдсан. Үүний дагуу Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс Даатгалын багц хуульд холбогдох өөрчлөлтийг оруулах саналыг боловсруулан Сангийн яаманд хүргүүлээд байна. Үүнд дотоодын давхар даатгалын салбарын хөгжлийг дэмжих, түүнчлэн дотоодын даатгагч нарыг чадавхжуулах, хамтран эрсдэл хүлээн авах болон хөрөнгийн зах зээлийн тусламжтайгаар эрсдэлийн удирдлагын арга хэрэгслийг боловсронгуй болгох боломжийг бүрдүүлэх асуудлуудыг тусгаад байна.

Үүнээс гадна “Даатгалын багц дүрэм”-ийн 13 дугаар хавсралт “Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага”-ын дагуу даатгагчийн давхар даатгалын үйл ажиллагааг зохицуулдаг ба үүнийг 2021 онд шинэчлэн баталснаар дотоодын давхар даатгагчийг дэмжих, мөн даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөө, тайланд тавих шаардлагыг сайжруулсан.

Цаг гарган бидэнтэй ярилцсан танд баярлалаа.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

ТОГТВОРТОЙ ҮНЭТ ЦААС

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах референт Н.Нарантуяа

Дэлхий даяар хүн төрөлхтөн байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагаа явуулах талаар анхаарал хандуулж байна. Үүнийг дагаад тогтвортой хөрөнгийн зах зээл аажмаар тэлж, тогтвортой гэх тодотголтой шинэ бүтээгдэхүүнүүд, хөрөнгийн бирж, зохицуулагчид, сангийн менежерүүд болон зах зээлийн бусад оролцогчдын тогтвортой хөрөнгийн зах зээлд оруулах хөрөнгийн хэмжээ болон санаачилгууд нэмэгдэж байна. Дэлхий нийтээрээ цар тахал, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх болсноор тогтвортой, ногоон хөрөнгө оруулалт 2020 онд өмнөх оны мөн үеэс 3.2 их наяд долларт хүрсэн нь Тогтвортой хөгжлийн зорилтод хүрэхэд санхүүжилтийн орон зайг нөхөх боломж хөрөнгийн зах зээлд буйг илтгэнэ.

Өнгөрсөн 5 жилийн хугацаанд хамтын болон биржээр арилжаалагддаг сангууд тогтвортой төслүүдийг хурднаар мэдэрч, хөрөнгө оруулалтын шалгууртаа байгаль орчин, нийгэм, засаглалын хүчин зүйлсийг нэмж үнэлдэг болсон.

Тогтвортой хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаатай холбоотой тогтвортой хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн тоо өсөж байна / Хүснэгтээр харуулав/. Тогтвортой хөрөнгө оруулалтын хэрэгсэлд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөрөнгө оруулалт татах, хамтарсан венчур, давуу эрхийн хувьцаа гаргах, хөрөнгө оруулалтын итгэлцэл гаргах төрлүүд хамаарч байна.

Хүснэгт. Тогтвортой, ногоон хөрөнгө оруулалтын хэрэгслүүд

ХУВЬЦААНЫ ТӨРӨЛ	ТОДОРХОЙЛОЛТ	ЖИШЭЭ
Исламик санхүүжилт /сүкүк гэх мэт/	Шариагийн хуулийн (Sharia law) хүрээнд гардаг Исламын санхүүгийн сертификат	Малайзын төслийн компани болох Тадау энерги 2017 оны 7 дугаар сард анхны ногоон сүкүкийг гаргасан. Нарны эрчим хүчийг санхүүжүүлэх 16 жилийн хугацаатай 58.0 сая ам.долларын гэрээ байгуулсан.
Төр, хувийн хэвшлийн түншлэл	Төрийн байгууллага, хувийн хэвшил хоорондын урт хугацааны гэрээ нийтийн хөрөнгө, үйлчилгээг дэмжиж, хөгжүүлэхэд зорьдог.	Индонезийн Улсын өмчит дэд бүтцийн санхүүжилтийн компани нь Засгийн газрын дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөрийг дэмжихээр төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны төсөлд хувийн болон олон талт санхүүгийн институттэй хамтардаг.
Хамтарсан венчур	Тодорхой төсөл, бизнесийн үйл ажиллагаанд хүрэх хоёр ба түүнээс дээш талуудын бизнесийн зөвшилцөл	Санпауэр капитал болон Ханнон Армстронг тогтвортой дэд бүтцийн капитал нь оршин суугчдын нарны системийг багцлан санхүүжүүлэх зорилгоор нэгдэж, 2018 оны 11 дүгээр сард 400.0 сая ам.долларын хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан.
Венчур капитал	Инновацлаг ногоон төсөлд оруулах сангийн хуваарилалт	Цэвэр энергийн шинэчлэлийн сан 2017 оны 4 дүгээр сард 5.0 сая Австрали долларыг Зэн экосистемд хөрөнгө оруулсан.
Давуу эрхийн хувьцаа ба мезанин бонд	Хөгжлийн банк болон Олон улсын санхүүгийн институтын хосолсон санхүүжилт. Ихэвчлэн зээлдэгч нар зээлийг урьдчилсан нөхцөлийн дагуу хувьцаанд хөрвүүлдэг.	Эй-Эм-Пи капитал нь Их Британийн нарны цэцэрлэгийн 247.0 сая паундын дахин санхүүжилтэд 37.0 сая паундын мезанин хөрөнгө оруулалтыг оруулсан.
Төслийн санхүүжилт	Ногоон төслийн багцыг санхүүжүүлэх үйл явц. Олон нийтэд арилжаалдаг тусгай зориулалтын компани урт хугацааны мөнгө гаргах ногоон хөрөнгийн сангаас бүрддэг.	Хотын хөгжлийн компани 71.0 сая ам.долларын өндөр хамгаалалттай сертификатжсан уур амьсгалын бонд гаргасан.
Хөрөнгө оруулалтын итгэлцэл	Ногоон төслийн багцыг санхүүжүүлэх үйл явц. Олон нийтэд арилжаалдаг тусгай зориулалтын компани урт хугацааны мөнгө гаргах ногоон хөрөнгийн сангаас бүрддэг.	АНУ-ын үл хөдлөхийн Ханнон Армстронг 2013 онд 100.0 сая ам.долларын хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан.
Дэд бүтэц/үл хөдлөх хөрөнгийн сан	Дэд бүтцийн төсөлд хөрөнгө оруулах сан. Сангууд нь холимог санхүүжилтийн бүтэцтэй.	Гленмонт партнер нь Европын цэвэр энергийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтад төвлөрдөг сангийн менежер. 2017 оны 10 дугаар сард тус сан нь Италийн салхин сэнсний багцад 190.0 сая еврогийн дахин санхүүжилт хийсэн.

Тогтвортой, ногоон хөрөнгө оруулалтын хэрэгслүүд нь зах зээлд шинээр бий болж байгаа тул хөрөнгө оруулагчдыг татах нэг хүчин зүйл нь эрсдэлийг бууруулах хөшүүргийг бий болгох юм.

Зээл, улс төр, хөрвөх чадвар, валютын зэрэг эрсдэлээс хөрөнгө оруулагчдыг хамгаалах баталгаанууд мөн ажилладаг.

Хүснэгт. Зээлийн нөхцөлийг сайжруулах механизм

ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ МЕХАНИЗМ	ТОДОРХОЙЛОЛТ	ЖИШЭЭ
Бүтэн болон хэсэгчилсэн зээлийн баталгаа	Зээлийн баталгаа нь дэд бүтцийн төсөл дэх өрийн хэрэгслийн төлөгдөхгүй байх эрсдэлээс хамгаалдаг.	Синдикатум 2018 оны 01 дүгээр сард 7 жилийн хугацаатай 2 транчтай 40.0 сая ам.долларын тэргүүн зэргийн хамгаалалттай ногоон бонд гаргасан. Гуарантко компани уг хоёр хэлцэлд 100 хувийн зээлийн баталгаа олгосон.
Хэсэгчилсэн эрсдэлийн баталгаа/ улс төрийн эрсдэлийн баталгаа	Гадаадын зээлдэгч нарт эрсдэлтэй зээл олгоход хөрөнгө оруулагч болон зээлдүүлэгч нарт олгодог баталгаа. Хэсэгчилсэн эрсдэлийн баталгаа/улс төрийн эрсдэлийн баталгаа нь валютын хөрвөх чадвар, зээл, дайн, зохицуулалтын эрсдэл гэх мэт давагдашгүй хүчин зүйлийн эрсдэлүүдэд баталгаа өгдөг.	Сэргээгдэх эрчим хүч, энергийн үр өгөөжийн төслүүдэд ихэвчлэн хэрэглэгддэг.
Хэсэгчилсэн эрсдэлийн своп	Хэсэгчилсэн своп баталгаа нь хөрөнгө оруулагчдыг хил дамнансан гүйлгээнд валютын эрсдэлээс хөрөнгө оруулагчдыг хамгаалдаг.	Бразилын хувийн хэвшлийн банк Юнибанко 25.0 тэрбум иений 10 жилийн хугацаатай өрийн бичиг гаргасан. Уг өрийн бичиг нь ам.долларын гуйвуулгаар баталгаажсан.
Анхны алдагдлыг нөхөх	Хөрөнгө оруулагчдыг хөрөнгийн алдагдлаас сэргийлэх хэрэгсэл. Үүнд мөн даатгал хамаарна.	ОУСК Ногоон бондын санг өсөж буй зах зээлд хөрөнгө оруулах зорилготой 2018 онд байгуулсан. Хувийн хэвшлээс хөрөнгө оруулалт татах, эрсдэлийг бууруулахаар анхны алдагдлыг нөхөх баталгааг гаргасан.
Нөхцөлт зээл	Нөхцөлт зээл нь тодорхой кейсүүдэд төлбөрийн сонголтуудыг олгодог.	



ФИНТЕК БА РЕГТЕК

ИНШҮРТЕКИЙН САЛБАРЫН ЦААШДЫН ХАНДЛАГА

Технологийн өсөлт нь өмч хөрөнгө, осол гэмтлийн салбарт, ялангуяа даатгалын зах зээлд томоохон өөрчлөлтүүдийг бий болгож байна. Өнгөрсөн жил Иншүртекийн хөрөнгө оруулалт рекорд тогтоосон нь тус салбарт бизнес эрхлэгчдийн даатгалын үйлчилгээний хүртээмж сайжирч, хэрэглэхэд хялбар дижитал үйлчилгээнүүд нэвтрүүлж хэрэглэгчдийг их татаж чадсан. Даатгалын компаниуд өөрсдийн бүтээгдэхүүнээ эрчимжүүлж, өрсөлдөгчдөөсөө түрүүлэхийн тулд технологийн шинэ шийдлүүдийг гаргаж ирсээр байна.

Хэрэглэгчид хүссэн үедээ, хялбар, дижитал системээр дамжуулан даатгалд хамрагдах хүсэлтэй байгаа нь уламжлалт аргаар шийдвэрлэхээс илүүтэй дижитал систем рүү шилжих шаардлага үүссэн. Иншүртект үргэлж нарийн төвөгтэй үйл явцыг дижиталчилдаг. Даатгалын компаниуд илүү олон үйлчилгээг дижитал хэлбэрээр хүргэхийн тулд онлайн платформуор дамжуулан хурдан бөгөөд хялбар дижитал үйлчилгээг санал болгож байна.

Автомашинны ослын улмаас учирсан хохирлыг тухай бүрд нь бүртгэдэг, ослыг зураг хавсаргах боломжийг олгодог гэх мэт бодит цагийн мэдээллийг цуглуулдаг програмууд аль хэдийн бий болсон. Энэхүү програм нь тухайн эд ангиудыг солиход хэр их зардал гарахыг тооцоолдог бөгөөд тээврийн хэрэгслийг засварлахад хэмнэлттэй эсвэл алдагдалтай эсэхийг тодорхойлдог.

Энэ жил мэдрэгч, зүүдэг төхөөрөмж зэрэг холбогдсон төхөөрөмжүүдэд илүү их ач холбогдол өгөх замаар хяналт тавих төлөв нэмэгдэж байна. Жишээлбэл, тэжээвэр амьтдын даатгалын зах зээлд нохой, мууранд зориулсан фитнес, байршлын хяналт гэх мэт төхөөрөмжүүдийг ашиглах болно. Энэ технологийг ашигласнаар даатгуулагчдад мэдээлэл солилцохын оронд үнийг бууруулах замаар урамшуулах боломжтой. Гэрийн тэжээмэл амьтад, тэдний эмзэг нөхцөл байдал, урт хугацааны зардлын талаар илүү их мэдээлэл цуглуулахын тулд даатгагчид дижитал технологийг нэвтрүүлэн, илүү сайн шийдвэр гаргахын тулд их өгөгдлийг ашиглаж байна.

Түүнчлэн даатгалын компаниуд өрсөлдөх чадвараа хадгалахын тулд зах зээлийг бүхэлд нь өөрчлөх боломжтой технологиудыг судлах шаардлага бий болж байна.

ХИЙМЭЛ ОЮУН УХААН



Хиймэл оюун ухааны технологи нь сүүлийн жилүүдэд хурдацтай хөгжиж байна. Даатгалын зах зээлд хиймэл оюун ухаан нь эргэлтийн мөчлөгийг сайжруулж, андеррайтерийн үйл явцыг өөрчлөх боломжтой. Мөн мэдээллийг илүү хурдан бөгөөд илүү нарийвчлалтай хянаж боловсруулж чаддаг. Машин сургалтын технологи нь нэхэмжлэлийн процессыг сайжруулж, автоматжуулах боломжтой. Ингэснээр нэхэмжлэлийг хурдан шийдвэрлэж, даатгагчид олон үйлчлүүлэгчийг хүлээн авч, илүү үр ашигтайгаар үйлчлэх боломжийг олгоно.

ДРОН



Дроныг даатгалын олон үйл ажиллагаанд ашиглаж болно. Хөдөө аж ахуйн судалгаанаас эхлээд хүн төрөлхтөнд аюултай газар нутгийг судлах, эрсдэлийн үнэлгээ, андеррайтерийн мэдээллийг нэгтгэх зэрэг сүүлийн жилүүдэд даатгалд дрон ашиглах нь олширч байна. Тухайлбал урьдчилан сэргийлэх засвар үйлчилгээ хийх, бодлого хэрэгжүүлэхийн өмнө эрсдэлийг тооцох, алдагдсаны дараах хохирлыг үнэлэх зэрэг орно.

ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ



Интернетийн эрин зуунд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь олон салбарт чухал үүрэг гүйцэтгэдэг. Даатгагч нь маркетингийн стратегия сайжруулах, зорилтот хэрэглэгчдэдээ хүрэхийн тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглах боломжтой.

ЧАТБОТ ФУНКЦ



Чатбот функц нь даатгагчид үйлчлүүлэгчидтэй илүү сайн харилцах, хүн бүртэй илүү сайн харилцаа тогтооход тусална. Даатгалын компаниуд өөрсдийн програм хангамжийг хэрэглэгчдэд ээлтэй байдлаар тогтмол шинэчилж, удирдсанаар зах зээлийн өсөлтийг эрс нэмэгдүүлж, ажилчдад ажлаа хянах боломжийг бий болгох бөгөөд хэрэглэгчдээс үнэ зөв мэдээллийг цаг алдалгүй солилцдог болно.

СУДЛААЧИЙН ИНДЭР

ТОГТВОРТОЙ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ БҮРДҮҮЛЭХ, ТҮҮНИЙ ЦАР ХҮРЭЭГ ХУРДАСГАХАД ТЕХНОЛОГИЙН ДЭВШИЛ

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны ажлын хүрээнд нийтдээ 102 улсын криптовалютын зохицуулалт, тэдний хууль тогтоомж, бодлогыг хамруулан судалснаас ихэнх улсууд нь криптовалютыг зохицуулах талаар арга хэмжээ авсан байв. Жишээ нь: Египет, Ирак, Балба, Арабын Нэгдсэн Эмират Улс, Алжир, Болив, Морокко, Пакистан, Вьетнам зэрэг улс орнууд криптовалютаар холбоотой аливаа үйл ажиллагааг хориглосон бол Катар нь иргэдээ улсын нутаг дэвсгэрт криптовалютаар холбоотой аливаа төрлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглодог боловч улсын хилээс гадна байгаа иргэдэд зөвшөөрдөг байна. Бангладеш, Тайланд, Литва, Лесото, Хятад, Колумб улс орнууд шууд бус хязгаарлалт хийсэн байдаг.

Улс орнуудын хөгжлийн түвшнээс хамаараад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь харилцан адилгүй байгаа ба хөгжлийн түвшин өсөх тусам хууль эрх зүйн орчинд өөрчлөлт хийх, тусгайлан хууль батлах зэргээр зохицуулалт хийсэн байна. Улсуудын хамгийн нийтлэг хэрэгжүүлсэн арга хэмжээ бол криптовалютаас үүдэн учрах эрсдэлээс сэрэмжлүүлэх, анхааруулах мэдэгдэл нийтэд түгээх байв.

УДИРТГАЛ

Технологийн дэвшлүүд ар араасаа гарч, зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрэх нь санхүүгийн инновац болон үр ашигтай байдлыг үүсгэж цаашлаад санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж байна. Гэвч энэ нь гэмт хэрэгтэн, террористуудад мөнгө угаах эсвэл өөрсдийн үйл ажиллагаагаа санхүүжүүлэх арга замуудыг бий болгож байдаг. Эдгээр технологийн дэвшилтэт шийдлүүдийн нэг нь виртуал хөрөнгийн нэг болох криптовалют юм.

Гүйцэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хорооны зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын мэргэжилтэн Б.Батболд batbold_b@frc.mn

Санхүүгийн зохицуулах хорооны зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн А.Мөнгөнсаран mungunsaran@frc.mn

Санхүүгийн зохицуулах хорооны зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын мэргэжилтэн С.Будбаяр budbayar@frc.mn

Санхүүгийн зохицуулах хорооны зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын мэргэжилтэн Б.Тэмүүжин temuujin@frc.mn

Санхүүгийн зохицуулах хорооны зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын мэргэжилтэн Б.Тэргэл tergel@frc.mn

Криптовалют нь үйл ажиллагааны, зах зээлийн, хөрвөх чадварын зэрэг эрсдэлүүдийг дагуулдаг учир хөрөнгө оруулагчид, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалахаас гадна санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах үүднээс улс орны зохицуулагч байгууллагууд зохицуулалтын арга хэмжээг авах шаардлагатай болсон.

Төв банк, санхүүгийн зохицуулагч байгууллагуудын зүгээс иргэд, олон нийтдээ криптовалютын үнийн хэлбэлзэл болон хууль бус үйл ажиллагаатай холбогдох эрсдэлийн талаар сэрэмжлүүлж, анхааруулах мэдэгдэл хийх нь хамгийн нийтлэг хэрэгжүүлж буй арга хэмжээ байв.

Криптовалют нь хэрэглэгчийг нэрээ нууцлан гүйлгээ хийх боломжийг олгодог мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх /МУТС/ эрсдэл үүсгэж болзошгүйг харгалзан үзэж зарим улсууд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх /МУТСТ/ тухай хууль, эрх зүйн актууддаа нэмэлт, өөрчлөлтүүдийг тусгах байдлаар криптовалютын үйл ажиллагааг зохицуулсан хэлбэртэй байна.

КРИПТОВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛ

Криптовалютын зах зээл нь анхдагч ба хоёрдогч зах зээл гэж ангилагддаг. Анхдагч зах зээлд криптовалютыг үүсгэх болон

үүсгэсэн токениг түгээх үйл ажиллагаа явагддаг. Криптовалютыг олборлолтоос өмнөх (pre-mining: бүх токенийг нэг дор гаргах), үргэлжлүүлэн олборлолт (continuous mining: ил тод, урьдчилан тогтоосон дүрмийн дагуу тасралтгүй тогтмол үүсгэх), холимог (hybrid: тодорхой хэсгийг нэг дор гаргаж, үлдсэн хэсгийг түүнээс хойш олборлох) гэсэн 3 төрлөөр үүсгэдэг.


Анхдагч зах зээлийн хүрээнд:

1. Токен гаргахаас өмнөх худалдаа: Хаалттай хүрээнд тодорхой хөнгөлөлттэйгөөр санал болгох;
2. ICO буюу токен гаргах: Олон нийтэд нээлттэй эсвэл хаалттай байдлаар санал болгох;

3. Олборлолт: Шинээр олборлох байдлаар токениг үүсгэх;
4. Airdrop: Өмнө нь байсан токенид шинэ төрлийн токен ногдуулж олгох;
5. Fork: DLT системийн хүрээнд дүрмийн өөрчлөлт бий болсноос үүдэн сүлжээ хуваагдах шаардлагатай болдог. Одоогийн токен эзэмшигчид 1-1 байдлаар шинээр токениг авах гэсэн 5 үндсэн үйл ажиллагаа явагддаг.

Улс орнуудын хувьд одоогийн байдлаар "airdrop" болон "fork" үйл ажиллагааг зохицуулсан туршлага байхгүй байна.

Зураг. Криптовалютын анхдагч зах зээл болон эрсдэлүүд



Эх сурвалж: Олон улсын валютын сан

Хоёрдогч зах зээлийн хүрээнд:

- Хуваарилалт;
- Хадгалалт;
- Бирж, арилжаа;
- Төлбөр тооцоо;

Олборлолт;
Хөрөнгө оруулалт болон бусад үйл ажиллагаа явагддаг ба үйл ажиллагааг эрхэлдэг дундын зуучлагчид болон үйлчлүүлэгчид, токен гаргагчаас бүрддэг.

Дундын зуучлагчдын үйл ажиллагаа болон тэдгээрийн үзүүлж болох үйлчилгээг харуулсан ба хөх өнгөөр криптовалютаас үүдэн цоо шинээр бий болсон үйл ажиллагааг, цагаан өнгөөр уламжлалт

буюу өмнө нь байсан үйл ажиллагааг, цэнхэр өнгөөр хосолмол буюу дээрх хоёрын шинжийг зэрэг агуулсан үйл ажиллагааг дүрслэв.

Хүснэгт. Дундын зуучлагчдын үйл ажиллагаа

Шинээр гаргах, хуваарилалт	Токен шинээр бий болгох, хуваарилах үйлчилгээ
	Андеррайтингийн үйлчилгээ
Хадгалалт	“Custodial” хэтэвчний үйлчилгээ
	“Non-custodial” хэтэвчний үйлчилгээ
Бирж, арилжаа	Төвлөрсөн биржийн үйлчилгээ
	P2P биржийн үйлчилгээ
Төлбөр тооцоо	Төвлөрсөн бус биржийн үйлчилгээ
	Харилцагчийн төлбөр тооцоо
Олборлолт	Улс дамнасан төлбөр тооцоо
	Ашиглагдах технологийн үйлдвэрлэл
	Зайнаас үйлчлэх
	Өмчийг “hash” хийх
Хөрөнгө оруулалт	Үүлэн олборлолтын үйлчилгээ
	Хамтын олборлолт
	Хөрөнгийн удирдлага
	Хамтын хөрөнгө оруулалтын схем
	Биржийн арилжаа
	Хөрөнгө оруулалтын зөвлөгөө
Бусад	Хөрөнгө оруулалтын сурталчилгаа
	Хөрөнгө оруулалтын зуучлалын үйлчилгээ
	ICO үнэлгээний үйлчилгээ
	Үнэт цаасны аудит
	Нягтлан бодох, хуулийн үйлчилгээ
	Комплайнс
	Дата үйлчилгээ
Програм хөгжүүлэлт	
	Блокчэйн шинжлэл

Эх сурвалж: Кембрижийн их сургууль

Токений ангилал

Криптовалютын зах зээл хурдацтай өсөн нэмэгдэхийн хэрээр санхүүгийн салбарт шинэ нэр томьёо гарч ирж байна.

Аргентин, Тайланд, Австрали – тоон валют

Канад, Хятад, Тайван – виртуал бараа

Герман крипто – токен

Швейцар – төлбөрийн токен

Итали, Ливан – кибер валют

Колумб, Ливан – цахим валют

Хондурас, Мексик – виртуал хөрөнгө гэх зэргээр улсууд өөр өөрөөр нэрлэсэн.

Хэдийгээр улс орнууд токений зориулалтыг харилцан адилгүй нэршлээр тодорхойлж байгаа ч ерөнхийдөө 3 үндсэн чиглэлийн дагуу ангилж зохицуулалтыг хийж байна.

Хүснэгт . Улсуудын токен ангилал

УЛС	ДИЖИТАЛ ТӨЛБӨР ТООЦОО, ШИЛЖҮҮЛЭГ	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТАЙ	ДИЖИТАЛ ПЛАТФОРМ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД АШИГЛАХ
Англи	Exchange token	Security token	Utility token
Арабын Нэгдсэн Эмират	Crypto Asset	Security token	Utility token
Герман	Payment token	Equity token	Utility token
Европын Холбоо	Payment/exchange/currency token	Investment token	Utility token
Израил	Currency token	Security/investment token	Utility token
Мальт	Virtual financial asset	Financial instrument	Virtual token
Швейцар	Payment token / cryptocurrency	Asset token	Utility token

Үүнд:

Төлбөр тооцооны токен / Криптовалют (Payment/exchange tokens)– Төлбөр тооцоо, арилжааны хэрэгсэл;

Хэрэглээний токен (Utility token) – Тодорхой нэг дижитал платформ эсвэл үйлчилгээний хүрээнд ашиглах боломжтой токен;

Үнэт цаасны токен (Security token) – Хөрөнгө оруулалтын хэрэгсэл багтана. Үнэт цаасны токений хувьд ихэнх улсууд үнэт цаасны тухай хууль болон тогтоомжийн дагуу зохицуулалтыг хийж байна.

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН ЗӨВЛӨМЖ**IOSCO – Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага**

Хэдийгээр криптовалютын арилжааны платформууд үйл ажиллагааны хувьд өөр байдаг ч үнэт цаасны арилжааны платформтой ижил төрлийн олон асуудлыг үүсгэдэг. Криптогийн платформ нь үнэт цаасны платформоос 2 үндсэн ялгаатай байдаг ба үүнд:

- Арилжааны хөрөнгө оруулагчид бие биетэйгээ шууд харилцах;
- Кастодианы үйлчилгээг давхар үзүүлэх боломжтой байдаг.

Өөрөөр хэлбэл ихэнх крипто платформуор дамжуулан арилжаа хийхээс илүүтэйгээр дундын зуучлагчийн үйл ажиллагаа явагддаг. Тиймээс үйл ажиллагааны асуудал, зах зээлийг урвуулан ашиглах, тодорхой бус байдал зэрэг уламжлалт үнэт цаасны арилжааны зах зээлд тулгардаг эрсдэлээс гадна хэд хэдэн нэмэлт асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байдаг.

Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO)–аас криптовалют/хөрөнгийн зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэхдээ эрх баригчид дараах хэд хэдэн элементийг анхаарч үзэх хэрэгтэйг онцолсон байна. Үүнд:

1. Бүртгэлжүүлэлт;
2. Тусгай зөвшөөрөл;
3. Тайлагналт;
4. Байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, засаглал;
5. Баталгаажуулалт;
6. Аюулгүй байдал;
7. Мэдээлэл хадгалалт;
8. Хөрөнгө оруулагч/үйлчлүүлэгчдийн эрх ашиг, тэдгээрт олгох мэдлэг;
9. Ил тод байдал;
10. Хөрөнгийн доод хэмжээ;
11. МУТСТ тухай зэрэг багтсан байна.

ФАТФ – Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага

Одоогоор дэлхийн улс орнууд виртуал хөрөнгийн (крипто валют) үйлчилгээ үзүүлэгчдийг хянах гурван төрлийн аргачлалаас бүтсэн систем ашиглаж байна. Үүнд:

1. Мэдээлэл дамжуулах ерөнхий бүтэц;
2. Баталгаажуулалтын бүтэц;
3. Хэрэглэгчийг баталгаажуулалт.

ФАТФ-ын зөвлөмжийн дагуу виртуал хөрөнгийн эцсийн эзэмшигчийг заавал бүртгэлжүүлж таних ёстой. Уг шаардлагыг “Travel rule” гэж нэрлэдэг. Эдгээр шаардлага нь зохицуулагч байгууллагад виртуал хөрөнгө, крипто валютаар мөнгө угаах болон терроризмын санхүүжүүлэхийн эсрэг үйл ажиллагаанд хяналт тавих стандарт болж өгдөг. Виртуал хөрөнгийг цахим орчинд арилжаалах, шилжүүлэх, төлбөрийн хэрэгсэл болгож ашиглах болон хөрөнгө оруулалт хийж болно. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч хувь хүн болон аж ахуй нэгж нь заавал бодит, үнэн зөв бүртгэлтэй этгээд байх ёстой. Тус шаардлагыг хэрэгжүүлэхийн тулд зохицуулагч байгууллагууд trust-network технологийг хэрэгжүүлдэг.


Виртуал хөрөнгийн мэдээлэл дамжуулах ерөнхий бүтэц

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн болон хэрэглэгчийн мэдээллийг дундын сүлжээгээр заавал дамжуулж байх ёстой. Эдгээр мэдээллийг сүлжээгээр тараахад дараах үндсэн шаардлагыг биелүүлсэн байх шаардлагатай ба үүнд:

1. Нууцлал, аюулгүй байдал: Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн бий болгосон сүлжээ нь хэрэглэгчийн мэдээллийг хуваалцахад зориулсан нууцлал, аюулгүй байдлын технологийг хэрэглэсэн байх ёстой;
2. Хэрэглэгчийг таньж баталгаажуулах: Хэрэглэгчийг таньж баталгаажуулахдаа бусдад тухайн мэдээллийг алдахгүй байх;
3. Гүйлгээ болгонд хэрэглэгчийн мэдээллийг агуулдаг байх. Хэрэглэгч хооронд гүйлгээ хийх болгонд тус бүрийн мэдээллийг үнэн зөв байгаа эсэхийг шалгах;
4. Эцсийн өмчлөгчийн мэдээллийг солилцон харилцан баталгаажуулах: Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь өөр виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай харилцан мэдээллээ солилцож, эцсийн өмчлөгчийг баталгаажуулдаг байх.

Баталгаажуулалтын бүтэц

1. Хэрэглэгчийн мэдээллийг илрүүлэх болон бизнесийн байгууллагыг баталгаажуулах: Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч болон түүнийг эзэмшигч хоёр харилцан өөрсдийн үнэн зөв мэдээллийг солилцох;
2. “Public-key”-р илрүүлэх болон баталгаажуулах: Виртуал хөрөнгийн сүлжээнд байгаа хэрэглэгчийг “public-key”-н тусламжтай илрүүлдэг байх;
3. Хэрэглэгчийг илрүүлэх.



Зураг. Мэдээлэл солилцох сүлжээний ерөнхий бүтэц

ФАТФ-с гаргасан эдгээр зөвлөмж шаардлагыг “Blockchain transaction investigation tool”-р хянах боломжтой. Эдгээр программ хангамж нь виртуал хөрөнгийн (ethereum сүлжээ) данс хооронд хийгдэж буй гүйлгээ, цахим түрийвчийн эзэн, гүйлгээ хаанаас хаашаа хийгдэж байгаа болон хэр их хэмжээний гүйлгээ хийж байгааг хянах боломжтой.

Эдгээр тоног төхөөрөмжийг тусгай серверт суулган хянах гэж буй Виртуал хөрөнгөө бүртгэж оруулснаар бүх шилжилт хөдөлгөөн, хэрэглэгч болон гүйлгээний дүнг хянах боломж олгодог. Виртуал хөрөнгө илгээгч, хүлээн авагч болон гүйлгээний дүнг цаг тухай бүрд нь мэдсэнээр татвар ногдуулах боломжтой. Мөн сэжигтэй гүйлгээг мэдээлэх чадалтай. Эдгээр системүүд нь комплайнс, ухаалаг гэрээ болон “block node” зэргийг аудит хийх боломжтой.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Улс орнууд криптовалютын зохицуулалтыг төрөл бүрээр авч хэрэгжүүлж байгаа ба манай улсын хувьд “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай” хуулийн төслийг боловсруулсан.

Олон улсын туршлагаас харахад одоогийн хүчин төгөлдөр хуулиудад өөрчлөлт, нэмэлт оруулах, эсвэл тусгайлан криптовалютын зохицуулалтыг шинэчлэн бүрдүүлэхээс гадна эрх бүхий байгууллагуудаас ICO, криптовалютаар холбоотой зөвлөмж, зааврыг боловсруулсан байна. Иймээс криптовалют/хөрөнгийн зохицуулалтыг боловсронгуй болгох үүднээс холбогдох заавар, зөвлөмжийг боловсруулах боломжтой юм. Тус заавар, зөвлөмжийн хүрээнд виртуал хөрөнгийн үйл ажиллагааны зориулалтаар ангилж үнэт цаасны тухай болон МУТСТ тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой.

Мөн зохицуулалтын сэндроксыг ашиглан криптовалют, блокчэйний компаниудын эрх зүйн орчин, зохицуулалтыг туршиж, сайжруулж болно. Мөн олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмжийн дагуу хяналт, зохицуулалтыг нэвтрүүлэх нь олон улсын сайн туршлагуудыг хэрэгжүүлэх эхлэлийг тавьж өгөх юм.



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

Цуврал №10

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд



НОГООН ДААТГАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Монгол Улсад ногоон даатгалыг: Монгол Улсын хууль тогтоомжид тусгагдсан “Ногоон таксономи”-ийн ангилалд хамаарах үйл ажиллагааг аливаа хэлбэрээр даатгаж буй сайн дурын даатгалын бүтээгдэхүүн гэж тодорхойлсон.



“Ногоон даатгал”-ын гол онцлог нь юу юм бол доо...

Байгаль орчинд ээлтэй ногоон төсөл, хөтөлбөрүүдийг аливаа эрсдэлээс хамгаалах, мөн хөрөнгө оруулалт, урт хугацааны санхүүжилтийг бий болгодог.



Байгаль орчинд ээлтэй, дахин ашиглаж болох материал, эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл ашиглахыг дэмжих, урамшуулах хөшүүргийг бий болгодог.

НОГООН ДААТГАЛЫН ЭЭРЭГ НӨЛӨӨЛӨЛ



Хүрээлэн буй орчинд эергээр нөлөөлнө



Нийгмийн хариуцлагыг сайжруулна



Олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлнэ

- 1 Хүртээмжтэй санхүүжилт, эрүүл мэнд
- 2 Уур амьсгал болон байгалийн гамшигт уян хатан дэд бүтэц
- 3 Тогтвортой хөдөө аж ахуй ба ойжуулалт
- 4 Ногоон барилга, хүлэмжийн хийн бага эсвэл тэг ялгаралтай тээврийн хэрэгсэл
- 5 Тогтвортой ус болон хог хаягдлын менежмент

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

Цуврал №10

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

Санхүүгийн зохицуулах хороо ногоон даатгалын бүтээгдэхүүнийг тодорхойлж, бүртгэдэг боллоо.

Приус
автомашины даатгал

Жишээ нь:

МОНГОЛ УЛСАД

Унадаг дугуйны
иж бүрэн даатгал

НОГООН ДААТГАЛ – ОЛОН УЛСАД

Олон улсад ногоон даатгалыг: байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэж буй эрсдэлийг бууруулах, даатгуулагч эрсдэлд ороход даатгалын нөхөн төлбөр олгох зориулалт бүхий даатгалын үйл ажиллагаа гэж тодорхойлдог.

ОЛОН УЛСАД БОРЛУУЛАГДАЖ БУЙ НОГООН ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН

Байгаль орчинд ээлтэй даатгал

Байгаль орчинд ээлтэй, дахин боловсруулагдахуйц материал ашиглах, эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгслийг худалдан авах үед хийгддэг.

Автотээврийн хэрэгслийн ногоон даатгал

Автомашинаараа хэдэн километр явснаас хамааран даатгалын хураамж төлдөг. Нийтийн тээврээр зорчих, алхах зэрэгт төлөх хураамжийн хэмжээ буурдаг.

Бизнесийн ногоон даатгал

Бизнес эрхлэгчид эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл ашиглах, байгальд ээлтэй стандартаар үйл ажиллагаа явуулах зэрэгт хамаардаг.


Аялал жуулчлалын ногоон даатгал

Аялал зугаалгад явахдаа байгаль орчинд ээлтэй тээврийн хэрэгслээр зорчих үед хийгддэг.

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

САНХҮҮГИЙН ТООЦООЛОЛД СУРАЛЦЬЯ (ХИЧЭЭЛ №5)



ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА В.ЭНХБААТАР

МӨНГӨН УРСГАЛЫН ШИНЖИЛГЭЭ; ЦЭВЭР ӨНӨӨГИЙН ҮНЭ ЦЭНЭ, IRR, ЖИГНЭСЭН ӨГӨӨЖ

Ирээдүйд орж ирэх мөнгөний урсгалуудыг төсөөлье, мэдээж зарим нь орлого (эерэг), зарим нь зарлага (сөрөг) байна. Эдгээр ирээдүйд орох (гаргах) мөнгөний урсгалууд тус бүрд хамаарах хугацаа, хүүгээс хамааран харилцан ялгаатай өнөөгийн үнэ цэнэ (PV) байна. Эдгээр орлого зарлагын өнөөгийн үнэ цэнийн нийлбэрийг 'цэвэр өнөөгийн үнэ цэнэ' (NPV) гэнэ.

7.5 хувь хорогдуулах хүүтэй дараах мөнгөний урсгалын цэвэр өнөөгийн үнэ цэнэ хэд вэ ?

1 жилийн дараа	+₮100
2 жилийн дараа	-₮50
3 жилийн дараа	+₮20

$$\frac{100}{(1 + 0.075)^1} - \frac{50}{(1 + 0.075)^2} + \frac{200}{(1 + 0.075)^3} = 214.18$$

Цэвэр өнөөгийн үнэ цэнэ (NPV)
Ирээдүйд тохиох мөнгөний урсгалуудын өнөөгийн үнэ цэнийн нийлбэр

Internal Rate of Return / IRR

IRR –ыг ихэнх сурах бичигт “өгөөжийн дотоод хувь” гэж орчуулсан байдаг. Энэ нь дотоод гэх утгатай “internal” гэх англи үгтэй холбоотой хадмал хөрвүүлэг юм. Угтаа энэ нь ирээдүйн мөнгөний урсгалуудын өнөөгийн үнэ цэнийг хорогдуулан тооцох ‘дискаунт хувь’ учраас үүгээр

нь нэрлэх нь илүү тохиромжтой. Мөнгөний урсгалын шинжилгээ хийхэд хорогдуулах аргаар ирээдүйд өөр өөр цаг хугацаанд тохиосон мөнгөний урсгалуудын ялгаатай хүү, эсвэл өгөөжийн хэмжээнээс хамааран тус бүрд нь ‘дискаунт фактор’ үүсгэн өнөөгийн үнэ цэнийг (PV) тооцдог аргачлалыг тайлбарласан.

IRR нь үүнтэй адил ирээдүйн мөнгөний өнөөгийн үнэ цэнийг тодорхойлох дискаунт хувь хэмжээ юм, ялгаа нь хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцоход зориулан ирээдүйн бүх мөнгөний урсгалд тохируулан үүсгэсэн ‘нэг’ үзүүлэлт юм. Мөн энэ ‘дискаунт хувь’-ийг тооцоолоход инфляц, валютын ханшны зөрүү гэх мэт бусад гадаад хүчин зүйлүүдийг хамтад нь тооцдоггүй тул ‘дотоод’ гэж тодотгон нэрлэдэг.

Хөрөнгө оруулалт	-164
1 жилийн дараа	45
2 жилийн дараа	83
3 жилийн дараа	75
Дискаунт хувь	10.59%

IRR–ын гол агуулга бол ирээдүйд тохиох мөнгөний урсгалуудын өнөөгийн үнэ цэнийг тооцоолох дискаунт хувийг тодорхойлох юм.

IRR нь ирээдүйд тохиох мөнгөн урсгалуудыг хорогдуулах аргаар, тэдгээрийн цэвэр өнөөгийн үнэ цэнийг анхны хөрөнгө оруулалтын хэмжээнд хүртэл тооцоолох дискаунт хувь юм. Хорогдуулан тооцоолсон цэвэр үнэ цэнэ ба анхны хөрөнгө оруулалтын нийлбэр ‘тэг’ байна.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХЯНАЛТ 2022 ОНД АНХААРАХ ГОЛ ЧИГЛЭЛҮҮД

БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО БА БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ /БОНЗ/-ЫН АСУУДАЛ

Компанийн нийгэмд гүйцэтгэх үүрэг хариуцлага улам нэмэгдэж буй энэ үед тухайн байгууллагын төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ нь бусад оролцогч талуудын хүлээлт шаардлагыг хангахуйц бараа, үйлчилгээг нийлүүлж, шинийг санаачлахад анхаарах ёстой. Хувьцаа эзэмшигчид урт хугацаанд илүү ашигтай байхын тулд бусад оролцогч талуудын ашиг сонирхлыг мөн адил анхаарах ёстой гэдгийг хүлээн зөвшөөрч, илүү өргөн хүрээнд санал солилцож байна.

Энэ өөрчлөлт нь ТУЗ-ийн гишүүдийн хуулийн дагуу хүлээх хариуцлага буюу компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлын төлөө ажиллах үүрэг хариуцлагад нөлөөлөөгүй хэвээр байна. Компани болон хувьцаа эзэмшигчдэд урт хугацаанд ашиг тусаа өгөх бизнесийн зорилго баримталдаг хэдий ч бусад оролцогч талуудын ашиг сонирхлыг харгалзан үзэх шаардлага зайлшгүй байдаг.

Компанийн зорилго, зорилгыг илүү өргөн хүрээнд авч үзэх нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч, ажилчид болон зохицуулагчдын БОНЗ-ын асуудлын сонирхол нэмэгдэж байгаатай холбоотой. Уур амьсгалын өөрчлөлт, Ковид-19 цар тахал, арьс өнгөөр ялгаварлан гадуурхалт болон бусад тэгш бус байдалд шаардлагатай арга хэмжээ авах нь байгаль орчин, нийгмийн асуудалд анхаарлаа хандуулж байгаа хэлбэр юм. Эдгээр асуудлыг компанийн зорилго, стратегитай холбох нь хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолд нийцүүлэх, компанийн урт хугацааны үнэ цэнийг нэмэгдүүлэхэд дэм болно.

Компани БОНЗ-ын асуудлыг зохистойгоор шийдвэрлэх нь хямралыг даван туулах, урт хугацаанд үнэ цэнийг бий болгох чадвартай холбоотой бөгөөд үүнийг стратегийн чухал асуудал гэж үзэх нь улам бүр нэмэгдсээр байна. ТУЗ, гүйцэтгэх удирдлага нь компанийн стратегийн талаар авч үзэхдээ уур амьсгалын өөрчлөлт, нууцлал эсвэл бусад нийгмийн асуудал гэх мэт БОНЗ-ын асуудлууд бизнест хэрхэн нөлөөлж болохыг, мөн эдгээр асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх хувилбаруудыг үнэлэх хэрэгтэй.

Хөрөнгө оруулагчид БОНЗ-ын санаачилгыг сонирхож, дэмжих нь эрс нэмэгдсэн ба энэ нь буурах төлөвгүй байна. Хувьцаа эзэмшигчдээс БОНЗ-той холбоотой асуудлаар гаргаж буй саналууд их байгаа бөгөөд ТУЗ-д үүнтэй холбоотойгоор эрсдэлүүдийн талаарх туршлага дутмаг байгааг онцолж байна.

Олон томоохон институцийн хөрөнгө оруулагчид БОНЗ-ын асуудалд өндөр гүйцэтгэлтэй байх нь үнэ цэнийг бий болгодог гэсэн үзэл баримтлалтай байгаа ба тэд байгаль орчин, тэгш байдал, оролцоо /DEI/ гэсэн асуудлаар компаниудтай хамтарч ажиллахыг эрмэлзэж байна. Тэд хувь нийлүүлэгчдээс 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг дуустал санал хураалт явуулсан ба байгаль орчин, нийгмийн асуудлаар олонхын буюу 20 хувь дэмжлэг авч дээд амжилтыг тогтоогоод байна. Уг санал асуулгыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 8 хувиар илүү дэмжлэг авчээ.

Төлөөлөн удирдах зөвлөл нь:

Гүйцэтгэх удирдлагаас оролцогч талуудын үзэл санаа, БОНЗ-ын асуудлуудыг стратегийн болон бизнесийн шийдвэр, түүнчлэн эрсдэлийн удирдлагад хэрхэн тусгаж байгааг анхаарах шаардлагатай. Үүнд зорилтуудын гүйцэтгэлийг хэмжих, зохих хэмжүүрүүдийг авч үзэх, ил тод байдлын хяналт, журмыг сайн дураар болон заавал мөрдөх, БОНЗ-ын ил тод байдлыг дэмжихэд чиглэгдсэн эсэхийг баталгаажуулах, гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулалд БОНЗ-ын урамшуулалтай холбоотой нөхөн олговрын зарим элементийг багтаасан байх зэрэг орно. ТУЗ, түүний дотор ТУЗ-ийн дэргэдэх хороод БОНЗ-ын асуудлаар хэрхэн хяналт тавьж байгааг анхаарна. Компаниас үзүүлж буй үйлчилгээ болон холбогдох үйл ажиллагаа нь оролцогч талуудын ашиг сонирхол болон нийгмийн сайн сайхны төлөө хэрхэн үйлчилж байгааг тодорхойлж, үүнийг компанийн шийдвэр гаргалтад зарчим болгон ашиглах хэрэгтэй.

Гүйцэтгэх удирдлагатай дараах асуудлаар ярилцах:

Үйлчлүүлэгчидтэй харьцахдаа санамсаргүй байдлаар ялгаварлан гадуурхах үйлдлийг тодорхойлохын тулд, бизнесийн үйл ажиллагааны үнэлгээ, боловсрол, эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, ханган нийлүүлэгчдийн олон талт байдал, нийгмийн шударга ёсыг дэмжих зэрэг БОНЗ-ын асуудлын хүрээ, зорилго, БОНЗ-ын тодруулга, нийгмийн хариуцлага эсвэл тогтвортой байдлын тайлан зэргийг компанийн цахим хуудсанд тусгах хэрэгтэй.

ХҮНИЙ НӨӨЦ БА АЖИЛЛАХ ХҮЧНИЙ АСУУДАЛ

Ковид-19 цар тахал, мэдлэгт суурилсан эдийн засагт шилжихтэй зэрэгцэн хүний нөөцийн үнэ цэнийг онцолж, бизнесийн хэрэгцээ, ажлын сонголт, хүмүүн капиталын зах зээл, түүнтэй холбоотой

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

эрсдэл (жишээлбэл, кибер аюулгүй байдал, комплайнс гэх мэт) зэрэгт өөрчлөлт оруулсан. Хүний нөөцийн менежментийн асуудал нь компанийн нэн чухал асуудлын нэг бөгөөд ТУЗ-ийн хяналтын гол салбар юм. Эдгээр асуудалд:

- Ажилтныг ажилд авах, дэвшүүлэх, хадгалах зэрэг авьяас чадварын менежмент;
- Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал;
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, эрх тэгш цалин, цалинтай чөлөө зэрэг шударга нөхөн олговор, тэтгэмж;
- Сургалт, карьер хөгжүүлэх санаачилга;
- Ажиллах хүчний менежментийн асуудал, тэр дундаа цомхтгол;
- Ялгаварлан гадуурхах, дарамтлах, дээрэлхэлтийн эсрэг авах арга хэмжээ зэрэг орно.

Төлөөлөн удирдах зөвлөл нь:

Гүйцэтгэх удирдлагатай ярилцах замаар одоогийн хөдөлмөрийн зах зээл компанид хэрхэн нөлөөлж байгаа, тэр дундаа ажилдаа эргэн орох бодлогын нөлөөлөл, ажилчдын сургалт, цалин, тэтгэмжид хөрөнгө оруулах төлөвлөгөө зэрэг хөдөлмөрийн хүндрэл, хомсдолд хэрхэн нөлөөлж байгаад анхаарах мөн ажилтныг хамгаалах, DEI-

ийг дэмжих зорилготой харилцаа холбоо, бодлогыг удирдлагын дээд түвшинд хэрэгжүүлэх шаардлагатай.

Гүйцэтгэх удирдлагатай дараах асуудлаар ярилцах:

Ажиллах хүчин, тэр дундаа ахлах түвшний DEI, цалин хөлс, боломжийн эрх тэгш байдлыг сайжруулах (сургалт, албан тушаал дэвших гэх мэт) болон ажилчдыг ажилд авах, цалинжуулах, тушаал дэвших зэрэгт ялгаварлан гадуурхах үйлдэл гаргахаас сэргийлэх;

Компанийн соёлд анхаарлаа хандуулж, удирдлага нь компани доторх ёс зүй, шударга харилцаа, DEI-г эрхэмлэж, шударга ёсыг төлөвшүүлэх;

Гүйцэтгэх удирдлагаас байгууллагын ёс зүйн дүрэм, зан байдлын талаар ажилчдад сургах үйл явцыг хянах;

Манлайлагчдыг татах, хадгалах болон гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлийг хүлээлттэй нь уялдуулах, зохих хөшүүрэг, урамшууллыг тодорхойлох;

Зохистой зан байдлыг урамшуулахын тулд урамшууллын төлөвлөгөөг дахин боловсруулах шаардлагатай эсэхийг анхаарч үзэх хэрэгтэй.

Үргэлжлэл бий...

Эх сурвалж: Harvard Law School Forum on Corporate Governance



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ДЭЛХИЙН БАНК: УКРАИНЫ ЭДИЙН ЗАСАГ 45.1 ХУВИАР АГШИХ ТӨЛӨВТЭЙ БАЙНА.



ВАШИНГТОН. /DW/. Украины эдийн засаг энэ онд 45.1 хувиар агших төлөвтэй байгааг Дэлхийн банк шинэ тайландаа дурдсан байна. Оросын түрэмгийллийн улмаас Украины бизнесийн үйл ажиллагаа зогсож, экспорт огцом буурч, салбаруудын эдийн засгийн үйл ажиллагаа тасалдаж, улмаар зогсонги байдалтай болсон. Дэлхийн банкны “Бүс нутаг дахь дайн” тайлангийн тооцоогоор Украины фирмүүдийн тэн хагсаас илүү хувь нь үйл ажиллагаагаа зогсоосон байна. Мөн Украины Хар тэнгисээр хийдэг тээвэрлэлт зогссон нь үр тарианы экспортын 90 хувь, нийт экспортын тэн хагас нь зогсох шалтгаан болсон.

Дэлхийн банкны таамаглалаар ОХУ-ын дотоодын нийт бүтээгдэхүүн 2022 онд Өрнөдийн орнуудын авсан санхүүгийн хориг арга хэмжээнүүдийн улмаас 11.2 хувиар буурна гэж урьдчилан таамаглажээ.

Эдийн засагчдын мэдээлж буйгаар, Украин, Беларусь, Молдаваас бүрдсэн Зүүн Европын бүс нутгийн дотоодын нийт бүтээгдэхүүн дайн, худалдааны тасалдлаас үүдэн 2022 онд 30.7 хувиар буурах төлөвтэй байгааг онцлов.

ОХУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАР ОНЦГОЙ БАЙДЛЫН ЗАРДЛЫН НӨӨЦИЙГ 3.52 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРООР НЭМЭГДҮҮЛНЭ.

МОСКВА. /Reuters/. Барууны хориг арга хэмжээнд өртөөд буй ОХУ эдийн засгийн тогтвортой байдлаа хангахаар онцгой байдлын зардлын нөөцийг 3.52 тэрбум ам.доллороор нэмэгдүүлэх болсноо мэдэгдэв.

Тус улсын Засгийн газраас 2022.04.10-нд гаргасан мэдэгдэлд, “Эдгээр санхүүжилтийг гаднын хориг арга хэмжээний нөлөөнд

буй эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээнүүдэд зарцуулна” гэжээ.

Мөн Засгийн газрын зүгээс бизнес эрхлэгчид болон хүүхэдтэй өрхүүдэд 1.0 их наяд гаруй рублийн санхүүгийн тусламж үзүүлэхээ амласан байна.

Засгийн газрын нөөц сан бол улсын төсвөөс гадуур яаралтай зардалд зарцуулагдах нөөц бөгөөд 2021 онд тус нөөц сангаас цар тахалтай тэмцэх нэг удаагийн нийгмийн зардалд зарцуулж байсан байна.

Нөөцийг нэмэгдүүлэх гол эх үүсвэр нь 2022 оны 01 дүгээр улиралд тус улсад орж ирсэн 271.6 тэрбум рублийн эрчим хүчний нэмэлт орлого хэмээн Засгийн газар мэдээлсэн.



Статистик мэдээллээр, ОХУ нь ЕХ-ны байгалийн хийн 40 орчим хувийг, газрын тосны гуравны нэгийг хангадаг. Олон улсын Эрчим хүчний агентлагийн хийсэн тооцооллоор ОХУ нэг өдөрт 400.0 сая ам.долларын байгалийн хий, 700.0 сая ам.долларын газрын тосыг ЕХ-нд нийлүүлдэг байна.

ГАЗРЫН ТОСНЫ ҮНИЙГ БУУРУУЛАХ ҮҮДНЭЭС УЛС ОРНУУД СТРАТЕГИЙН НӨӨЦӨӨ АШИГЛАЖ ЭХЭЛЛЭЭ.

Олон улсын эрчим хүчний агентлагийн гишүүн орнууд олон улсын нөхцөл байдлаас шалтгаалан газрын тосны зах зээлийн үнэ ханшийг тогтворжуулах, эрчим хүчний зах зээл дэх тасалдлыг нөхөхийн тулд стратегийн нөөцөө ашиглаж байна.

Гишүүн орнуудын зөвлөлдөх уулзалтаар нийт 120 сая баррель газрын тос гаргахаар шийдвэрлэсэн. Үүний 50.0 хувь буюу 60 сая баррель газрын тосыг АНУ болон Япон харин Өмнөд Солонгос 7.23

сая баррель газрын тос тус тус гаргахаар шийдвэрлэжээ. Гишүүн орны энэ шийдвэрийн дараа газрын тосны ханш гурван өдөр дараалан буурсан.

Өмнөд Солонгосын Засгийн газрын хувьд олон улсын болон дотоодын зах зээлийн үнийг тогтворжуулах, эдийн засагт үзүүлэх дарамтыг бууруулах зорилгоор стратегийн нөөцөө ашиглаж байна. Мөн Сөүлийн энэ шийдвэр нь олон улсын эрчим хүчний агентлагийн гишүүн орны хувьд хамгийн өндөр дүн юм.

Үүний зэрэгцээ АНУ мөн нэг өдөрт 1.0 сая баррель газрын тос зах зээлд нийлүүлнэ гэж мэдэгдсэн. Вашингтоны энэ шийдвэр нь стратегийн нөөцийнхөө 30 гаруй хувийг шавхаж байгаагаас гадна 1984 оноос хойш 40 орчим жилийн хугацаанд Америкийн стратегийн нөөц түүхэн доод түвшинд хүрч буурахаар байгааг олон улсын хэвлэлүүд мэдээлж байна.



Үндсэндээ энэ шийдвэрүүд нь үнийн савлагааг тогтоон барих, газрын тосны импортын хараат байдал буурах нөхцөлийг бүрдүүлэх болов уу гэж олон улсад таамаглаж байна. Түүхий эдийн зах зээлийн өнөөгийн тогтворгүй байдал нь суурь үзүүлэлтийн өөрчлөлтөөс илүүтэй геополитикийн нөхцөл байдалтай холбоотой гэж гишүүн орнууд үзэж байна.

ЕВРОПТ ШАТАХУУНЫ ҮНЭ ХАМГИЙН ӨНДӨР БАЙНА.

Дэлхийн хамгийн үнэтэй шатахууныг Европын орнуудад худалдаалдаг. 4 дүгээр сарын 2-ны өдрийн мониторингийн судалгаанаас харахад тус бүс нутагт 4 литр шатахуун 6.0 ам.долларын үнэтэй байгаа юм.

Өөрөөр хэлбэл шатахууны үнийг өнөөдрийн ханшаар тооцвол нэг литр нь 4,500.0 төгрөгтэй тэнцэнэ. АНУ-д ийм хэмжээний түлш 4.0–5.0 ам.доллар байгаа бол Канадад арай илүү үнэтэй буюу 6.0 ам.доллар байгаа аж. Харин Латин Америк, БНХАУ-д 5.0–6.0 ам.доллар орчимд хэлбэлзэж байна.

Брент төрлийн газрын тосны ханш 3 өдөр дараалан буурсан үзүүлэлттэй байсан бол 4 дүгээр сарын 3-ны өдрийн байдлаар ханш эргэн өссөн байна. Тухайлбал, брент төрлийн газрын тос 0.9 хувиар өсөж, 101.0 ам.доллар болж хэлбэлзэж хэлбэлзсэн. WTI маркийн газрын тосны ханш 1.3 хувиар буурч, 96.0 ам.доллар болж хэлбэлзэж байна.

BLOOMBERG: ОХУ 2022 ОНД ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭКСПОРТООР \$321 ТЭРБУМЫН АШИГ ОЛНО.

“Хэдийгээр олон улсын хоригт өртсөн ч “ОХУ 2022 онд газрын тос, байгалийн хийн экспортоор 321.0 тэрбум ам.долларын ашиг олно” хэмээн Bloomberg агентлаг мэдээлсэн.



Олон улсын санхүүгийн хүрээлэнгийн үнэлгээгээр урсгал ажиллагааны цэвэр ашиг нь 240.0 тэрбум ам.долларт хүрч гэсэн дээд амжилт тогтоохоор байна. “Хоригтой ч хатуу валютын урсгал тасрахгүй. Үүнд Оросын нефть, хийд тавих бүрэн хэмжээний хориг л саад болно” гэж өгүүлжээ.




ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр

S&P 500 /^GSPC/


4,525.12 -121.88 (-2.77%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /^N225/


27,093.19 -532.60 (-1.96%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /^FTSE/


7,483.40 -106.27 (-1.39%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite (^IXIC)

12,839.29 -335.41 (-2.55%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com



© САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia

